



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2026 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр, Пүрэв гараг**

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-7
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	8-58

<b>Өргөн мэдүүлсэн төслийн талаар мэдээлэх</b>	8-9
<b>1. Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан нарын 3 гишүүн 2025.12.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>	9-43
<b>2. Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай</b>	43-45
<b>3. “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</b>	45-50
<b>4. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.03.19-ний өдөр яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>	50-58

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
4 дүгээр сарын 02-ны өдөр /Пүрэв гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 83 гишүүн хүрэлцэн ирж, 65.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 32 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Мөнхтуяа;

Чөлөөтэй: Х.Баттулга, М.Мандхай, М.Нарантуяа-Нара;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Х.Болормаа, А.Ганбаатар, Ж.Ганбаатар, Б.Уянга, Л.Энхнасан;

Тасалсан: Д.Амарбаясгалан, Ц.Даваасүрэн;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-52 минут, Н.Алтаншагай-03 минут, С.Амарсайхан-13 минут, Х.Баасанжаргал-03 минут, Ц.Баатархүү-03 минут, Э.Бат-Амгалан-03 минут, О.Батнайрамдал-1 цаг 19 минут, Б.Баярбаатар-03 минут, Ж.Баярмаа-02 минут, Э.Болормаа-05 минут, Х.Булгантуяа-09 минут, Д.Ганбат-03 минут, Л.Гантөмөр-03 минут, М.Ганхүлэг-03 минут, Т.Доржханд-03 минут, Б.Дэлгэрсайхан-03 минут, Б.Жавхлан-31 минут, Д.Жаргалсайхан-03 минут, П.Мөнхтулга-03 минут, Ч.Номин-05 минут, О.Номинчимэг-03 минут, Н.Номтойбаяр-03 минут, Л.Оюун-Эрдэнэ-1 цаг 59 минут, Г.Хосбаяр-23 минут, П.Сайнзориг-03 минут, О.Саранчулуун-03 минут, Б.Тулга-22 минут, Д.Цогтбаатар-02 минут, Ж.Энхбаяр-13 минут, М.Энхцэцэг-13 минут, Р.Эрдэнэбүрэн-15 минут.

**Өргөн мэдүүлсэн төслийн талаар мэдээлэх**

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүнээс 2026.03.30-ны өдөр өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд хуваарилсныг мэдээлэв.

Цаг үеийн асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга А.Ариунзаяа үдээс өмнөх хуралдааны хэлэлцэх асуудлуудаар 14:00 цаг хүртэл завсарлага авах тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 14:00 цаг хүртэл завсарлага өгөв. /10:35/

Үдээс өмнөх хуралдаан 03 минут үргэлжилж, 10 цаг 35 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 06 минутад эхлэв.

**Нэг.Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан нарын 3 гишүүн 2025.12.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Боловсролын яамны Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга М.Цогзолмаа, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Л.Баттөр, мөн газрын Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Цэцэгсайхан, Удирдахуйн ухааны доктор М.Намхайринчэн, Анагаах ухааны доктор Д.Нарансүх, О.Чимэдсүрэн, Хууль зүйн ухааны доктор Д.Ганхүрэл, Б.Оюунжаргал, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Б.Буянтогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Б.Мажигсүрэн, референт Б.Энхмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Д.Бум-Очир, Н.Наранбаатар, С.Эрдэнэбат, А.Ариунзаяа, О.Саранчулуун, Д.Ганбат, Х.Баасанжаргал, Н.Алтаншагай, Х.Булгантуяа, П.Наранбаяр нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан, Анагаах ухааны доктор Д.Нарансүх, О.Чимэдсүрэн, Хууль зүйн ухааны доктор Д.Ганхүрэл, Б.Оюунжаргал, Удирдахуйн ухааны доктор М.Намхайринчэн, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Б.Буянтогтох нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа, О.Номинчимэг нар үг хэлэв.

**Ж.Бат-Эрдэнэ:** Байнгын хорооны саналаар Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73  
Татгалзсан: 41  
Бүгд: 114  
64.0 хувийн саналаар дэмжигдлээ.

***Хамт өргөн мэдүүлсэн:***

1.Байнгын хорооны саналаар Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72  
Татгалзсан: 42  
Бүгд: 114  
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76  
Татгалзсан: 38  
Бүгд: 114  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76  
Татгалзсан: 38  
Бүгд: 114  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 16 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.*

### ***Хоёр.Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хуралд олонхын суудал авсан Монгол Ардын намаас Улсын Их Хурлын даргад Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогтыг нэр дэвшүүлснийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Батжаргал танилцуулав.

Улсын Их Хурлын даргыг сонгох тухай асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл ажлын 3 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ ажлын 1 өдрийн завсарлага өгөв. /16:13/

***Гурав. “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, мөн яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга Б.Алимаа, Нийгмийн

даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, мөн газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх М.Отгон нар байлцав.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир, Ц.Туваан, Д.Ганбат нарын тавьсан асуултад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, мөн яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал нар хариулж, тайлбар хийв.

**Ж.Бат-Эрдэнэ:** “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	79
Татгалзсан:	35
Бүгд:	114

69.3 хувийн саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул хуралдааны тэмдэглэлд саналаа дэмжсэнээр тэмдэглүүлэх санал гаргаж, 70.2 хувийн саналаар хууль батлагдлаа.

“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталсанд тооцов.

*Уг асуудлыг 16 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.03.19-ний өдөр яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, мөн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Гаалийн ерөнхий газрын Татвар, орлогын газрын дарга С.Баярмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нар танилцуулав.

Танилцуулга болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Р.Сэддорж, Л.Гантөмөр, Д.Ганбат нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, мөн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай нар хариулж, тайлбар хийв.

**Ж.Бат-Эрдэнэ:** “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	67
Татгалзсан:	47
Бүгд:	114

58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, С.Одонтуяа, П.Батчимэг нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул хуралдааны тэмдэглэлд саналаа дэмжсэнээр тэмдэглүүлэх санал гаргаж, 61.4 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 17 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.*

**Бусад.** Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагайгийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 154 дүгээр сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн урилгаар Орхон аймгийн Эмпати сургуулийн багш нар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн урилгаар Чингэлтэй дүүргийн иргэдийн төлөөлөл, Төв аймгийн Аргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнийн урилгаар Булган аймгийн Рашаант сумын Улаанбаатар хотод суралцдаг оюутнуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын урилгаар нийслэлийн Монгени сургуулийн 10в ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын урилгаар нийслэлийн Гэгээ сургуулийн 9, 10 дугаар ангийн багш, сурагчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэнгийн урилгаар Дорнод аймгийн “Найнги” ХХК-ийн ажилчид, Орон нутгийн Онцгой байдлын газрын орлогч дарга нар Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 4 дүгээр сарын 01-нд төрсөн өдөр нь тохиосон Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга, 4 дүгээр сарын 02-нд төрсөн өдөр нь тохиосон Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 2 цаг 59 минут үргэлжилж, 126 гишүүнээс 114 гишүүн хүрэлцэн ирж, 90.5 хувийн ирцтэйгээр 17 цаг 02 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ГАЗРЫН  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

*2026 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр, Пүрэв гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 00 минут.*

### **НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

---

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгаж, гишүүдийн ирцийг та бүхэнд танилцуулъя. 126 гишүүнээс 83 гишүүн ирж, 65,9 хувьтай ирц бүрдсэн байна. Ингээд Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 2-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 3 асуудлыг хэлэлцсэн.

1. Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

2. “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр” соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

3. “Тогтоод нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д “Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хорог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ.” гэж заасан байгаа.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

1. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Жудагийн Баярмаа нарын 32 гишүүн 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд хуваарилсан.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Ариунзаяа.

**А.Ариунзаяа:** Та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе. Та бүхэн бүгд бас мэдээлэл авч байгаа байх. Үүссэн улс төрийн нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Ардын намын Удирдах зөвлөл яг одоо улс төрийн шийдвэр гаргах гээд хуралдаж байгаа. Мөн түүнчлэн араас нь Монгол Ардын намын бүлгийн хурал бас

энэ Удирдах зөвлөлөөс гарах улс төрийн чиглэлийг хэлэлцэх ийм хуваарьтай байгаад байгаа.

Тэгэхээр ийм учраас бүх гишүүдийн оролцоог энэ хэлэлцэж байгаа асуудлуудтай холбоотой хангахын тулд үдээс өмнөх чуулганы хуралдаанд эдгээр хэлэлцэж байгаа асуудлуудаас түр завсарлага авч, ер нь үдээс өмнөх хуралдааныг түр зогсоож хойшлуулж өгөхийг хүсэж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн тавьсан саналын дагуу үдээс өмнөх чуулганд завсарлага өгч байна. 14 цагаас чуулган эхэлнэ.

10.35 цаг.

## ЗАВСАРЛАГА

**Ж.Бат-Эрдэнэ:** Гишүүдийг танхимд урьж байна. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг 2026 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 14 цаг хүртэл завсарлага авсан. Завсарлага дууссан байна.

Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн даргаас үг хэлэх үү. Үг хэлэхгүй юу.

Хэлэлцэх асуудалдаа орьё.

**Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Тогтмолын Мөнхсайхан танилцуулна. Мөнхсайхан гишүүнийг индэрт урьж байна.

**Т.Мөнхсайхан:** Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дарга, гишүүд ээ,

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдөр Монгол Улсын ирээдүй болсон хүүхэд, залуучуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах асуудлын хүрээнд боловсруулсан Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төслийг танилцуулж байна.

Уг хуулийн төслийн бодлогын зорилттой уялдсан байдлыг авч үзэхэд Монгол Улс 2050 он гэхэд эрүүл насжилтаар бүс нутагтаа тэргүүлэх 10 улсын 1 болох зорилтыг дэвшүүлсэн. Энэ зорилгод хүрэхийн тулд бид иргэдийнхээ эрүүл насжилтыг дор хаяж 6 насаар нэмэгдүүлэх шаардлагатай. Энэ зорилгын суурь нь хүүхэд нас юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох эрхийг баталгаажуулсан. Гэвч бодит байдал дээр эдгээр эрхүүд сургуулийн орчинд бүрэн хангагдаж чадахгүй байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод эрүүл, зөв дадалтай иргэнийг багаас нь төлөвшүүлэх гэж тодорхой заасан. Иймд сургууль бол зөвхөн мэдлэг олгох газар бус эрүүл амьдралын хэв маяг, аюулгүй зан үйл төлөвшүүлэх үндсэн орчин байх ёстой. Өнөөгийн бодит нөхцөл байдлыг авч үзэхэд Монгол Улсад нийт 1,3 сая орчим хүүхэд багачууд амьдарч байгаа нь нийт хүн амын 36,2 хувийг эзэлж байна.

Үүнээс 2025-2026 оны хичээлийн жилд 820 орчим мянган хүүхэд ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгааг Үндэсний статистикийн хорооноос мэдээлсэн. Өөрөөр хэлбэл хүүхдийн дийлэнх хэсэг нь өдөр тутмын амьдралынхаа ихэнх хугацааг сургуулийн орчинд өнгөрүүлж байгаа нь тус орчны аюулгүй байдал, эрүүл мэндийн хамгаалалтыг төрөөс онцгойлон анхаарах шаардлагатайг илтгэж байна.

Өвчлөлийн хувьд шүдний өвчлөл хүүхдүүдийн дунд тэргүүлэх шалтгаан хэвээр, амьсгал, хоол боловсруулах замын өвчлөл өндөр, сүрьеэгийн өвчлөл буурахгүй байна.

Осол гэмтлийн хувьд Монгол Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн хугацаанд 6-18 насны нийт 250 мянга орчим хүүхэд осол гэмтэлд өртсөн бөгөөд үүний 13,5 буюу 33.689 тохиолдол нь сургуулийн орчинд бүртгэгдсэн байна. Сургуулийн орчинд гарсан осол гэмтлийн шалтгааныг дотор нь зам тээврийн осол, амиа хорлох оролдлого, хүчирхийлэл зэргийн улмаас үүссэн тохиолдлууд сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байгаа нь анхаарал татаж байна.

Хамгийн ноцтой нь хүүхэд сурч боловсрох зорилгоор очсон сургуулийн орчинд эрүүл мэндэд эрсдэл учруулах, цаашлаад амь насаа алдах харамсалтай тохиолдлууд бүртгэгдсээр байна. Сургуулийн орчны эрсдэлийг авч үзэхэд НҮБ-ын Хүүхдийн сангийн захиалгаар 2024 онд хийсэн хүүхдийн орчны эрүүл мэндийн үнэлгээ судалгааны үр дүнг харвал 79 хувь нь хурд сааруулагчгүй, замтай ойр, 73 хувь нь аюулгүй спортын талбайгүй, 76 хувь нь ил задгай цахилгааны утасны эрсдэлтэй, 51 хувь нь авто замтай хэт ойр байна.

Дотоод орчны эрүүл ахуйн хүрээнд сургууль, цэцэрлэгт засвар хийсний дараа будаг бусад материалаас ялгардаг формальдегид стандарт хэмжээс 2-3 дахин их, бензол 3,5 дахин их, хар тугалга 2-5 дахин их, хром 2,3 дахин хэтэрсэн нь дотоод орчны судалгаагаар тогтоогдсон. Эдгээр бодис нь хорт хавдрын эрсдэл, дархлаа сулрах, хүүхдийн өсөлт хөгжилд сөргөөр нөлөөлөх, архаг амьсгалын замын өвчин ихсэх эрсдэлийг дагуулдаг.

Нийгмийн тулгамдсан асуудал сургуулийн орчинд дээрх асуудлаас гадна сурагчдын хоорондын харилцаа хандлагатай холбоотой ноцтой асуудал болох үе тэнгийн дээрэлхэл бодитоор байгаа боловч түүнийг зохицуулах урьдчилан сэргийлэх тогтолцоо хангалтгүй байна. Энэ нь өнөөгийн сөрөг нөхцөл байдлыг бий болгоход нөлөөлж байна. Судалгаанаас харахад сургуулийн орчинд гарч буй осол гэмтлийн тэргүүлэх шалтгаануудын дунд хүчирхийлэл, дээрэлхлээс үүдэлтэй гэмтэл бэртэл өндөр хувийг эзэлж, эхний 4 дэх шалтгаан болж байна.

Иймд сургуулийн орчинд үе тэнгийн дээрэлхлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээ авах, сурагчдад сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг

үзүүлэх цогц тогтолцоог бүрдүүлэх нь хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах бодлогын чухал чиглэл болж байна. Үе тэнгийн дээрэлхэлтэй холбоотой харилцааг Хүүхэд хамгааллын тухай хуульд тодорхой хэмжээнд зохицуулсан боловч сургуулийн орчин дахь эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудалтай уялдуулсан, урьдчилан сэргийлэх болон дэмжлэгийн механизмыг нарийвчлан тусгасан зохицуулалт дутмаг байна.

Иймээс сургуулийн орчинд эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл дээрх зохицуулалтыг уялдуулан тусгаж, хамтын ажиллагааг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх болон хамгааллын тогтолцоог сайжруулахад чиглэсэн заалтуудыг түлхүү тусгасан болно.

Олон улсын туршлагыг харахад дэлхий дахинд сургуулийн орчны эрүүл мэндийг системтэй шийдсэн туршлага байна. Тухайлбал, ДЭМБ-аас Эрүүл мэндийг дэмжих сургууль хөтөлбөр хэрэгжүүлдэг. Уг хөтөлбөр нь сургуулийг бүхэлд нь хамарсан бодлого, орчин, үйлчилгээ, оролцоогоор дамжуулан хүүхэд болон хамт олны эрүүл мэнд, сайн сайхны байдлыг дэмжих цогц хөтөлбөр юм.

НҮБ-ын Хүүхдийн сан хүүхдийн аюулгүй орчны стандартыг тодорхойлсон. Хүүхдийн аюулгүй орчин гэдэг нь хүүхдийг аливаа эрсдэлээс хамгаалж, эрүүл аюулгүй хөгжих, суралцах, сэтгэл зүйн дэмжлэг авах нөхцөлийг бүрдүүлсэн орчин хэмээн тодорхойлсон. Монгол Улс эдгээр сайн туршлагыг нутагшуулах шаардлагатай байна.

Иймд хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг сургуулийн орчинд бүрэн хангах, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, урьдчилан сэргийлэх цогц тогтолцоог бүрдүүлэх нь төрийн бодлогын тэргүүлэх чиглэл байх шаардлагатай байна.

Бусад хуультай давхцаж буй эсэх, тэдгээрийн уялдаа холбооны талаар. Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл Хүүхэд хамгааллын тухай хуультай давхардуулалгүйгээр суралцагчийн сэтгэл зүйн боловсрол, зөвлөгөө өгөх, тусламж, дэмжлэг авах орчныг бүрдүүлэх, сургуулийн сэтгэл зүйч, эмч, холбогдох албан тушаалтан, суралцагчаас тогтмол асуулга авах гэх мэт арга замаар суралцагчийг хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхлийн хохирогч болж буй эсэхийг илрүүлэх боломжийг олгоно. Суралцагчийг хохирогч болж болзошгүй тохиолдолд яаралтай Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хамгаалах эрхийг сэргээх арга хэмжээ авах боломжийг бүрдүүлж өгөхийг зорьсон.

Үүгээр уг хуулийн төсөл нь Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан зохицуулалтуудтай давхардалгүй, харин Хүүхэд хамгааллын тухай хуулийг бодитоор хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар хууль хоорондын уялдааг хангаж өгсөн. Хэрэгжихгүй норм стандарт байх нь хоосон цааснаас ялгагдах зүйлгүй бөгөөд сургуулийн орчинд суралцагч хүүхдүүд нь амь насаараа эрсдэх, эрүүл мэндээрээ хохирох явдал буурахгүй гарсаар байна.

Сургуулийн орчны эрүүл мэнд аюулгүй байдлын тухай хуулийн төсөл нь сургуулийн орчинтой холбогдох норм стандартыг заавал дагаж мөрдүүлэх эрх зүйн үндэслэл, механизмыг бүрдүүлэхийг зорьсноороо онцлогтой. Үүнд норм стандартыг дагаж мөрдөөгүйгээс үүсэх хариуцлагын асуудлыг тусгаснаас гадна дагаж мөрдөж буй оролцогч талуудыг урамшуулах зохицуулалтыг ч орхигдуулаагүй.

Энэхүү хуулийн төсөл нь 4 бүлэг, 27 зүйлтэй.

1 дүгээр бүлэгт Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хууль нь өмчийн хэлбэр харгалзахгүй бүх шатын сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэндийг хамгаалж, дэмжих, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжилтэд хяналт тавих харилцааг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон олон улсын гэрээнд нийцүүлэн ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүмүүнлэг, нууцлалыг хангаж, суралцагчийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих зарчмаар зохицуулахад оршихоор тусгалаа.

2 дугаар бүлэгт Эрүүл мэндийг дэмжих сургуулийн нэгдсэн бодлогыг улсын хэмжээнд баталж, сургууль бүр хэрэгжүүлэх, суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах дунд хугацааны төлөвлөгөө, тогтмол үзлэг, шинжилгээ, эрт илрүүлэг, яаралтай тусламжийн бэлэн байдал, цахим бүртгэл, тайлагнал, нотолгоонд суурилсан төлөвлөлт, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, сэтгэл зүйн дэмжлэг, эрүүл мэндийн боловсролыг цогцоор нь хэрэгжүүлэх замаар суралцагч, багш, ажилтны эрүүл аюулгүй орчныг бүрдүүлж, хүүхдийн эрүүл мэндийг системтэй хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд чиглэгдэх юм.

3 дугаар бүлэгт сургуулийн орчны аюулгүй байдлыг хангах аливаа осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн стандартын хэрэгжилтийг хангах, түүнээс учирсан нөхөн төлбөр олгохтой холбоотой дараах агуулга бүхий зохицуулалтыг тусгалаа. Түүнчлэн сургуулийн орчинд тавигдах нэмэлт шаардлагыг тусгасан бөгөөд цаашдаа суралцагчдыг орчны бохирдол, тэдгээрээс улбаатай өвчлөлөөс урьдчилан сэргийлэх боломжтой болно.

4 дүгээр бүлэгт тус хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдох санхүүгийн олон талт эх үүсвэрийг ашиглаж болох эрх зүйн үндэслэлийг тусгалаа.

Эрхэм гишүүд ээ,

Хүүхдийн эрүүл мэнд бол зөвхөн эрүүл мэндийн салбарын асуудал биш ээ. Энэ бол улсын хөгжлийн суурь асуудал юм. Эрүүл боловсролтой иргэн эх орны хөгжлийн үндэс юм. Сургууль бол хүүхдүүд амьдралынхаа хамгийн их цагийг өнгөрөөдөг орчин. Тиймээс бид энэ орчныг эрүүл, аюулгүй хамгаалалттай болгох үүрэгтэй. Иймд сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Төслүүдийн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дуламын Бум-Очир гишүүн танилцуулна. Бум-Очир гишүүнийг урьж байна.

Улсын Их Хурлын гишүүн Алтаншагайгийн урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 154 дүгээр сургуулийн 12.2 дугаар ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багш, сурагчдад хичээл сурлагын өндөр амжилт хүсэн ерөөе.

**Д.Бум-Очир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Мөнхсайхан, Мандхай, Энх-Амгалан нараас 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтыг хангах, хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох боломжийг бүрдүүлэх, суралцагчдын эрүүл мэнд, зан, хууль, сургуулийн орчныг төрөөс анхаарах хэрэгцээ шаардлагыг үндэслэн хуулийн төслийг боловсруулсан бөгөөд хуулийн төслийг баталснаар сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, аюулгүй орчинд сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, аливаа өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавихтай холбогдсон эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нөхцөл бүрдэнэ гэж үзсэн байна.

Хуулийн төсөлд сургуулийн орчинд эрүүл мэндийн тогтолцоог бий болгох, сургуулиар дамжуулан суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх, сургуулийн орчны аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг тусгажээ.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалыг баримтлан Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг баталснаар улсын төсөвт 16.201.908.595 төгрөгийн зардал шинээр үүснэ гэж хууль санаачлагчид үзжээ.

Хуулийн төслийг D-Parliament цахим хуудаст байршуулж, иргэд олон нийтийн санал авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Зулпхар, Саранчулуун нар хуулийн төсөл нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрх зүйн зохицуулалттай хэрхэн уялдсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганмаа, Ганхүлэг нар бие даасан хуультай байхын хэрэгцээ шаардлага бий эсэх, Улсын Их Хурлын гишүүн Зулпхар, Галбадрах, Болормаа нар шинээр бий болж байгаа чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлын тооцоо хийсэн эсэх, санхүүжилт, төсөвт үүсэх ачааллын талаар, Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл, Галбадрах нар сургуулийн орчинд тавигдах нэмэлт шаардлага нь сөрөг үр дагавар үүсгэх эрсдэлтэй эсэх, Улсын Их Хурлын гишүүн Галбадрах, Ганхүлэг, Хэрлэн нар хуулийн үйлчлэлд хамаарах бусад түвшний сургалтын байгууллагын талаар асуулт асууж, хариулт авсан.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Ганмаа бусад хуулиар зохицуулсан харилцааг бие даасан хуулиар зохицуулах нь хуулийн давхардал үүсгэсэн эсэхэд судалгаа хийсэн эсэх, зардал, үр өгөөжийн харьцааг бодитой үнэлсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл сургуулийн орчны болон хүнсний эрүүл ахуйн

харилцааг дэлгэрэнгүй зохицуулах боломжтой эсэх, мөн хяналт шалгалт, төлөвлөлт хариуцсан субъектийн ялгааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Саранчулуун дотуур байрны асуудлыг хэрхэн тусгасан талаар, Хүүхэд хамгааллын тогтолцоо хамтарсан багийн үйл ажиллагааг хэрхэн сайжруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Бум-Очир үе тэнгийн дээрэлхлийг зохицуулсан заалт бий эсэх, Улсын Их Хурлын гишүүн Галбадрах сургалтын орчин, норм норматив, стандартыг хангах асуудлыг хэрхэн тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Найдалаа суралцагчид ноогдох хувьсах зардлын бүрэлдэхүүнд үзлэг шинжилгээний зардал багтсан эсэх талаар, мөн сургуулийн захиралд шинээр бий болж байгаа нэмэлт чиг үүрэг оновчтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганхүлэг дархлаажуулалтын хяналттай холбоотой зохицуулалтыг нэмж оруулах боломжтой эсэх, хүүхдийн дасгал хөдөлгөөн урьдчилан сэргийлэлтийг дэмжсэн зохицуулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Болормаа хууль хэрэгжсэнээр 5 жилийн дараа гарах бодит үр дүн, өөрчлөлтийг хэрхэн харж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Хэрлэн сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалах зохицуулалт тусгагдсан эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ганмаа давхардал үүсгэсэн зохицуулалтыг хасах, мөн шинжлэх ухаанд суурилсан тооцоо судалгаатай, үнэн зөв мэдээлэлд үндэслэн зардал, үр өгөөжийн харьцааг бодитой нарийвчилж тооцох, хуулийн төсөл батлагдсанаар сургалтын байгууллагын үйл ажиллагаанд ачаалал нэмэгдэх тул санхүүжилтийн бодит дэмжлэг үзүүлэх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл хуулийн агуулгыг хүүхдийн эрүүл байлгах асуудлын суурь болсон анги дүүргэлтэд чиглүүлэх, сургуулийн орчинд үе тэнгийн дээрэлхлээс сэргийлэх боломжийг бүрдүүлсэн зохицуулалт тусгах, түүнчлэн хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг хиймэл оюун ухааны платформыг ашиглан хийх шаардлагатай байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Найдалаа тус хуулийн төсөл нь салбар дагнасан хандлагыг халахад нөлөөтэй. Иймд хуулийн зохицуулалтыг оновчтой болгох замаар давхардал хийдлийг арилгах шаардлагатай талаар тус тус санал хэлсэн.

Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 72,2 хувийн саналаар.

Хамт өргөн мэдүүлсэн, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 77,8 хувийн саналаар, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 77,8 хувийн саналаар, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 77,8 хувийн саналаар тус тус үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Найдалаа гэжээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Мөнхөөгийн Цогзолмаа Боловсролын яамны Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга, Батмөнхийн Цэцэгсайхан Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Лхагваагийн Баттөр Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний төвийн захирал, Мандахын Намхайринчэн Удирдахуй ухааны доктор, Улсын Их Хурлын гишүүний ажлын алба, Батсүхийн Буянтогтох Улсын Их Хурлын гишүүний ажлын алба, Нарангийн Тунгалагсайхан Улсын Их Хурлын гишүүний ажлын алба, Дамирангийн Нарансүх Анагаах ухааны доктор, профессор, Очирын Чимэдсүрэн Анагаах ухааны доктор, профессор, Дамбаагийн Ганхүрэл Хууль зүйн ухааны доктор, Баатарын Оюунжаргал Хууль зүйн ухааны доктор.

Боловсролын яамны Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга байна уу. Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. Нэрс гарч ирлээ. Боловсролын яамныхан ирээрэй.

Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн.

**С.Эрдэнэболд:** Баярлалаа. Улсын Их Хурал дахь Хүний эрхийн дэд хорооны даргын хувьд бас Хүний эрхийн Үндэсний Комисс болон хүний эрхийн чиглэлийн байгууллагуудтай харилцан ажиллах хүрээнд, энэ хүүхдийн эрхийн асуудал бол маш том ноцтой асуудал болдог. Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн жил тутмын гаргаж байгаа мэдээлэл дээр ч гэсэн ер нь бол хүүхдүүд яагаад хүчирхийлэлд өртөж байгаа. Ямар нөхцөл байдалд тэр хүчирхийлэлд өртөгдөх шалтгаан нөхцөл нь болж байгаа гээд маш олон зүйлүүдийн статистик бол байгаа юм.

Тэгэхээр 1 зүйл байна. Өнгөрсөн 2025 онд Дархан, Сэлэнгэ, Төв аймгийн 1-12 дугаар ангийн 72.334 хүүхдэд Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан, Далайн Батбаяр бидний зүгээс бас захидал хүүхэд болгонд бичиж, тулгамдаж байгаа асуудлуудын талаар бас мэдээлэл авсан. 5 мянга гаруй захиа ирсэн. Уржнан 2024 онд бас 69.369 захидлын энэ 3 аймгийн 1-12 дугаар ангийн сурагч нарт явуулсан. Эндээс ер нь бол нийтлэг түгээмэл асуудал, ялангуяа орон нутагт тохиолддог асуудал бол сургуулийн орчны аюулгүй байдлын асуудал бол зонхилох 1 дүгээр хувилбар байдаг. Одоо зам хөндлөн гарах ч гэдэг юм уу, ялангуяа манай Сэлэнгэ аймгийн Баянгол, Дархан-Уул аймгийн Хонгор, Төв аймгийн Баянчандмань, Эрдэнэ, Баяндэлгэр, Баян гээд яг өндөр хурдны зам тууш дамжин өнгөрч байгаа газрууд сургуулийн хүүхдүүд зайлшгүй гарцаар гарах болдог. Үзэгдэх орчныг хязгаарлагдмал нөхцөл гэдэг ч юм уу ийм аюулгүй байдлын асуудлууд бол номер нэг асуудал байдаг.

2 дугаар асуудал юу байдаг вэ гэхээрээ золбин нохой ч гэдэг юм уу яг тодорхой хэмжээнд аюулгүй байдалд нь шууд заналхийлсэн зүйлүүд бол байдаг.

Үүний дараагийн асуудал нь болох юм бол 3 дугаар асуудал нь бол тоног төхөөрөмж хүрэлцээний хангамжийн асуудал бол зайлшгүй байдаг. Ингээд манай

тойрогт хийсэн судалгаагаар 4 дүгээр асуудал нь бол яг хүүхэд хоорондын асуудлууд бол орж ирдэг. Тэр тусмаа өсвөр насны эрэгтэй хүүхдүүдийн дундах амиа егүүтгэх асуудал бас аймшигтай түвшинд ингээд хүрчихсэн байж байгаа.

Тэгэхээр ер нь бол яах вэ, аливаа зүйлийг тодорхойлохоор тухайн мөн чанарын бусад зүйлийг нь бас анзаарахгүй өнгөрчих гээд байдаг учраас яг энэ сургуулийн орчны хүүхдийн эрхийн асуудал гэхээс илүүтэйгээр энэ чинь цогцолбор байдлаараа цахим орчин дахь буюу сошиал орч орчин дахь нөгөө ялгаварлан гадуурхалт гэж байна. Яг сургуулийн орчинд гэж агшаах нь хэр зөв байдаг юм бэ. Хүүхдийн эрхийг хамгаалсан хууль, одоо байгаа зохицуулалтын хүрээнд энэ асуудлыг сайжруулж боловсронгуй болгох зүйл байгаагүй юу. Зайлшгүй энэ тодотголтой хууль орж ирэх нь бусад зүйлүүдийнх нь ач холбогдлыг бууруулчих нөхцөл байдал байхгүй юу гэдэг асуулт.

Дараагийн нэг зүйл нь юу юм бэ гэхээрээ олон улсын одоо FOSS буюу Forum of Small States байгууллагаас гаргасан судалгаагаар 10 саяас доош хүн амтай улс орнуудын хөгжлийн 1 дүгээр гол зүйл бол боловсролын систем дэх хөрөнгө оруулалт. Боловсролын үр өгөөж. Хүний эрхийн Үндэсний Комиссоос гаргасан судалгаагаар ээж аавынх нь орлого, хаана амьдарч байгаагаас хамаарч хүүхдүүдийн боловсролын гарааны тэгш байдал алдагдаад байгаа юм. Тэгэхээр энэ хүний эрхийн асуудал бол суурь асуудал учраас үүнийг ялгаварлан гадуурхахтай, тэр гарааны өөр өөр нөхцөлөөс эхлэхээс илүүтэйгээр Монгол Улсын хаана ч байсан сурагч хүн, хүүхэд хүн эрхээ хамгаалуулдаг, тэр нь виртуал орчинд байна уу, бодит орчинд байна уу хамгаалуулдаг ийм иж бүрэн тогтолцоо хэрэгтэй байгаад байгаа. Ажлын хэсгээс асуухад энэ тэгвэл орчныг сайжруулахын тулд хэд хэдэн хууль араас нь гарч ирж цогцоороо хангагдах юм бэ. Бид нар ингээд 1 асуудлыг олон ангилдаг. Хүчирхийлэл гэж ангилдаг. Bullying буюу ингээд маш олон төрлөөр ангилчихдаг. Энэ салбар дундын 1 салбар дотор байгаа хууль, эрх зүйн долгион тааруулах зүйл дээр цаашлаад ямар эрх зүйн орчныг нэмж оруулах юм бэ гэсэн асуултыг асуугаад хариултаас нь хамаараад тодруулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэн хариулах вэ. Мөнхсайхан гишүүн.

**Т.Мөнхсайхан:** Гишүүний асуултад хариулъя. Ер нь хүүхдийн эрхийн талаар нэлээн хэд хэдэн хууль, эрх зүйн орчны зохицуулалт байгаа л даа. Боловсролын тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль гээд. Бид нар өнгөрсөн хугацаанд энэ хуулиудыг дагаж мөрдөж ирсэн. Тэгсэн боловч хүүхэд, залуучууд сурч боловсрох, эрдэм мэдлэг олохоор зорьж очиж байгаа сургуулийн орчиндоо эрүүл мэнд, амь насаараа хохирох тохиолдол өдөр ирэх тусам нэмэгдсээр байна. Тэгээд энэ хууль үнэхээр шаардлагатай юм уу гээд хэрэгцээ шаардлагын судалгаануудыг хийсэн. Энэ хууль бол үнэхээр хэрэгтэй байна гэдэг нь тогтоогдсон. Нөгөө талаасаа бид нар олон улсын хуулиудыг хууль, эрх зүйн орчнуудыг судалсан. Энэ дээр бол сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хууль бол өсвөр үе, хүүхдүүдийнхээ эрүүл мэндэд анхаардаг бүх улсуудад энэ хууль байгаад байгаа юм. Тийм учраас өнөөдөр манай улсад бол сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хууль зайлшгүй шаардлагатай байна. Бид нар аливаа асуудлыг үүссэнийх нь дараа ямар хариуцлага тооцох вэ гэж ингэж шийддэг биш, үүсэхээс өмнө хэрхэн яаж сэргийлэх вэ гэдэг энэ зүйл заалтууд энэ хуулийн төсөл дээр маш их орсон. Тэр сэтгэл зүйн дарамтад ордог, амиа хорлодог энэ асуудлууд сургуулийн орчинд өдөр ирэх тусам гарсаар байгаа. Тэгвэл энэ хууль дээр тусдаа сэтгэл зүйн

зөвлөгөөний асуудал тусгагдсан байгаа. Бусад хуулиуд дээр сургууль бол сэтгэл зүйчтэй л байна гэдэг зүйлийг тусгасан болохоос биш, сэтгэл зүйч нь яг ямар ямар ажлуудыг хийж, хэрхэн яаж урьдчилан сэргийлэх вэ, яаж энэ үе тэнгийн дээрэлхлийг үүсгэхгүй байх вэ гэдэг тал дээр авах арга хэмжээнүүдийг тодорхой тусгаагүй.

Тийм учраас энэ хууль дээр маш тодорхой зүйл, заалтуудыг тусгаж, хүүхдүүд сургуулийнхаа орчинд очиж амь нас, эрүүл мэндээрээ хохирдоггүй, осол гэмтэлд өртдөггүй, үе тэнгийн дээрэлхэлд өртдөггүй байх энэ боломжийг бүрдүүлэх зорилгоор энэ хуулийг санаачилж өргөн барьсан байгаа. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаншагайгийн урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 154 дүгээр сургуулийн 12.3 дугаар ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна. Багш, сурагчдад сурлага, хөдөлмөрийн өндөр амжилт хүсэн ерөөе.

Эрдэнэболд гишүүн тодруулъя.

**С.Эрдэнэболд:** Мөнхсайхан сайд аа, энэ хууль санаачлагчид нэг зүйлийг бас анхаараач ээ гэж. Ер нь аливаа улсын энэ манай улс жишээлбэл үндэсний сөрөн тэсвэрлэх чадвар гэж байгаа. Ирээдүйн иргэддээ ямар байгаасай гэж үздэг юм бэ гэдэг нь бол үндэсний сэтгэлгээнийх нь тэр код буюу суурь мөн чанар дээр боловсролын салбар суурилдаг байх ёстой. Өөрөөр хэлбэл Монгол хүн гэж ямар хүн байх ёстой юм. Монгол хүний үнэт зүйл, эрхэм чанар, энэ нь боловсролын тогтолцоонд яаж ул суурьтай болох юм бэ гэдэг асуулт бол 1 дүгээр асуудал. Эндээсээ үзээд зан төлөв гэж байдаг. АНУ-д бол одоогоор 50 гаруй зан төлөвийг 1-12 дугаар ангидаа заадаг. Европын орнууд, Скандинавын орнууд бол 120 орчим зан төлөвийг боловсролынхоо хөтөлбөрт оруулдаг. Монгол Улсад энүүгээрээ бол бид нар хомсодсон байгаа юм. Тэр утгаараа бол мэндлэх, хүндлэх, хүн чанартай байх, хүмүүжилтэй байх гэдэг нь социалист ойлголт гэхээсээ илүүтэйгээр хүний мөн чанарын ойлголт гэдэг зүйл байгаа юм.

Тэгэхээр энэ хатуу дэд бүтэц зөөлөн дэд бүтэцтэй уяж оруулахгүй бол ..../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хэллээ. Дуламын Бум-Очир гишүүн.

**Д.Бум-Очир:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Миний хэлэх гэж байгаа санал бол энэ дээрэлхэл гэдэг нэр томъёог хуульдаа тусгаж өгвөл яасан юм бэ. Хуулийн томъёолол болгож оруулбал яасан юм бэ гэсэн ийм саналтай байгаа. Дэлхийн улс орнуудад бол яг энэ дээрэлхлийн эсрэг дээрэлхлээс хамгаалах хуультай байдаг юм байна. АНУ-ын мужууд, Япон, Солонгос, Филиппин зэрэг улс орнууд бол сургуулийн орчинд, ер нь сурагчдын дундах үе тэнгийн дээрэлхлээс хамгаалах дээрэлхлийн эсрэг хуультай байна. Бид бүхэн мэдэж байгаа. Саяхан болж өнгөрсөн үйл явдал дээр бол энэ хүүхдүүдийн дундах дээрэлхлийн асуудал бол маш их хэмжээгээр нийгэмд яригдсан. Тэндээс 1 зүйлийг ажиглах хэрэгтэй. Дээрэлхэл гэдэг нэр томъёог маш ихээр хэрэглэдэг болжээ. Яг энэ сурагчдын дунд болоод байгаа асуудлыг дээрэлхэл гэдэг нэр томъёогоор бид нар хэрэглэж ярьж ойлгодог, хэвшчихсэн ийм нөхцөл байдал бий болчихжээ.

Нэгэнтээ нийгэм дээр хэрэглээ нь дээрэлхэл гэдэг нэр томьёо ороод ирчихсэн, хэвшчихсэн. Тухайн асуудлаа дээрэлхэл гэдэг нэр томьёог хэрэглэж ярьж, хэлж заншиж байгаа бол хуульдаа энэ нэр томьёог оруулж өгвөл яасан юм бэ. Өнөөдрийн энэ хүүхэд хамгаалалттай холбоотой байгаа, хүүхдийн эрхтэй холбоотой байгаа, боловсролын холбоотой хуулиудад манай Монголын 1 ч хууль дээрэлхэл гэдэг нэр томьёо маань хуулийн нэр томьёо болж орж өгөөгүй байгаа. Тэгээд би бол юу гэж ойлгож байгаа вэ гэхээр дээрэлхэл гэдэг энэ зүйлийг хуулийн нэр томьёо болгож оруулж өгөх нь дээрэлхлээс хамгаалах, дээрэлхлээс урьдчилан сэргийлэх, дээрэлхлийг таслан зогсоох хамгийн чухал эхлэл болох болов уу гэж бодож байгаа юм.

Тийм учраас дээрэлхлийн тухай бие даасан хуультай болдоггүй юм гэхэд бие даасан хуультай болох хэрэгцээ шаардлага хараахан үүсээгүй байна гэж үзвэл ядаж холбогдох аль нэгэн хуульд жишээ нь өнөөдөр л яригдаж байгаа энэ хуульд дээрэлхэл гэдэг нэр томьёог томьёолон оруулаад, тэгээд тусгайлан заалт болгоод дээрэлхлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх гэдэг агуулгаа тусгавал яасан юм бэ гэсэн ийм саналтай байгаагаа илэрхийлмээр байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хэллээ. Нанзадын Наранбаатар.

**Н.Наранбаатар:** Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр намайг хөдөө, орон нутагт ажиллаж байхад бол нэг сумын сургуулийн хүүхэд тэр сургуулийн гадна хашааныхаа хайсан дээгүүр давах гэж байгаад, бэртээд эндэж байсан тийм тохиолдол байгаа. Тэгэхээр өнөөдөр Монгол Улсад байгаа сургуулиуд ихэнх нь л иймэрхүү байдалтай л байгаа. Гаднаа нүхтэй, нүхэн жорлонтой, гэрэлтүүлэг байхгүй, камер байхгүй. Тэгээд л зам руу шахаад, хажуугаар нь машин зам явж байгаа, нүх сүвтэй хашааны хайс нь дээшийгээ үзүүртэй ч юм уу. Тэгээд л мал амьтан орчихоор ийм байдалтай. Ер нь та бүхэнд ямар судалгаа байгаа юм. Монгол Улсад хэдэн сургууль байгаа юм. Хэдэн сургууль нь яг тэр MNS стандартын шаардлага хангачихсан сургууль байгаа юм. Хэд нь шаардлага хангаагүй байгаа юм. Тэгэхээр энэ стандартын шаардлага хангуулахад хэдий хэмжээний төсөв хэрэгтэй юм бэ. Тэр стандартын шаардлага хангасан хашаа хайс, тэгээд нүх сүвийг бөглөх, дотор жорлонтой болгох, тэр цахилгааны ил утсыг далд хийх, камер, гэрэлтүүлэг хийхэд өнөөдөр хэчнээн хэмжээний төсөв хэрэгтэй байгаа юм. Би Төсвийн байнгын хорооны дарга учраас асууж байгаа юм.

Мөн сургууль дээр энэ хуулийн төслийг харах юм бол ингээд 9 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллана гэж байгаа юм. Хоол зүйч, сэтгэл зүйч, эрүүл ахуйч гээд сумын сургуулиуд ийм боловсон хүчин байгаа юм уу гэдэг асуудал байна.

Мөн жил болгон тодорхой хугацаанд үзлэг шинжилгээ хийлгэнэ, оношилгоо хийлгэнэ гэж байна. Энэ мөнгө хаанаас гарах юм. Эрүүл мэндийн даатгалын сангаас Эрүүл мэндийн даатгалын сангаас гарч болох юм уу. Хувьсах зардал дээр байх юм уу. Энэ хэрвээ хууль батлагдвал хэдий хэмжээний төсөв бас энэ дээр хэрэгтэй болох юм. Тэгээд л цаашлах юм бол сургуулийн ширээ, сандлаас өгсүүлээд л асар их зардлууд гарна. Өнөөдөр орчны эрүүл ахуйн шаардлага хангасан сургууль бол миний бодлоор ер нь их цөөхөн байгаа байх гэж бодож байгаа.

Тэгэхээр төсөв, санхүүгийн тооцоолол талаас л би асууя гэж бодож байгаа юм. Одоо сургуулиуд чинь хоол өгдөг болсон. Хоолны заалтай, гал тогооны хэрэгсэл нь

бүрэн хангагдсан сургууль хэчнээн байгаа юм. Хэдий хэмжээний төсөв хөрөнгө хэрэгтэй юм гээд асар их л төсөв, хөрөнгө шаардагдсан ийм л хууль ороод ирлээ. Хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй. Тэгээд энэ дээр та бүхэнд ямар тооцоо байгаа юм. Хаанаас энэ эх үүсвэр нь гарах юм. Хэдэн жилийн дараа энэ нь шаардлага хангадаг болох юм. 1 жилдээ 1 далайлтаар бол хийж чадахгүй байх. Хэрвээ энэ хууль батлагдчихлаа төсөв мөнгөгүйгээс болоод саяын миний ярьсан ажлууд хийгдэж чадахгүй бол хэн хариуцлагыг нь хүлээх юм. Төсвийг нь тавьж өгөөгүй Сангийн сайд хүлээх юм уу. Баталж өгөөгүй Их Хурлын гишүүд, аймгийн Хурлын Төлөөлөгч нар хүлээх юм уу. Төсөв, мөнгөгүй сургуулийн захирал хариуцлага хүлээх юм уу гээд хэрэгжихгүй хууль гарчих вий гэсэн ийм л болгоомжлол байх юм. Тэгэхээр та бүхэн энэ дээр ямархуу тооцоо судалгаанууд хийсэн юм. Төсөв хөрөнгө талаас нь надад нэг хариулаад өгөөдхөөч.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тогтмолын Мөнхсайхан гишүүн.

**Т.Мөнхсайхан:** Бид нар бүх талын бас судалгаануудыг хийсэн. Энэ стандарт шаардлага хангахгүй сургууль бол ер нь 50-аас дээш хувьтай байна. Хүүхдүүд сурч боловсрох гэж очдог сургууль дээрээ очоод амь насаараа хохирч байгаа тохиолдлууд өнгөрсөн хугацаанд цөөнгүй гарлаа. Гэсэн хэдий боловч энэ бол хэвийн асуудал мэт бид нар тоохгүй өнгөрөөдөг. Ийм болтлоо нөхцөл байдал хүндэрсэн байна. Тэр орон нутагт ялангуяа сумын сургуулиудад дотор ариун цэврийн өрөөтэй, 00-той болгох асуудал хөрөнгө мөнгө тавиад шийдэгддэг. 1 жил хэрэглээд, дараа жилээс нь байхгүй болчихдог. Тэгээд энэ бол хүүхдийн эрүүл мэндэд асар их хор хөнөөлтэй. Гэтэл энийг тогтмол үйл ажиллагааг хангаагүйн улмаас хэн нэгэн, ямар нэгэн хариуцлага хүлээхгүй байгаа.

Тийм учраас энэ хариуцлагын тогтолцоог бий болгоё. 4 жил тутмын сургуулийн эрүүл, аюулгүй байдлын орчныг хангах энэ төлөвлөгөөгөө сургууль болгон боловсруулаад, тухайн аймаг, орон нутагтайгаа хамтарч энийгээ батлаад, ирэх жил аль аль үйл ажиллагааг нь хэрэгжүүлэх юм бэ. Тэрэнд ямар хэмжээний төсөв мөнгө хэрэгтэй юм бэ гэдэг энэ зүйлүүдээ дээшээ төр захиргааны байгууллагууд руугаа уламжлаад энэ асуудлаа шийдүүлдэг болгохгүй бол өнөөдөр энэ стандарт хангахгүй, эрүүл, аюулгүй орчныг хангахгүй сургуулиуд өдөр ирэх тусам нэмэгдсээр байна. Энийг бууруулахын тулд бид нар энэ хууль, эрх зүйн орчныг сайжруулахаас өөр аргагүй.

Нэг амьсгаагаар бид нар энэ стандартыг, нормуудыг бүгдийг нь хангуулна гэх юм бол маш их хэмжээний төсөв мөнгө шаардагдана. Бид нар бол энийг шууд 1 жилийн дотор шийд гэдэг ийм хуулийн төсөл бол огтоосоо биш. Сургууль болгон өөрсдийнхөө онцлогт таарсан хангагдахгүй байгаа энэ эрүүл, аюулгүй орчноо сайжруулах төлөвлөгөөгөө гаргаад, тухайн орон нутаг нь бас энд нь зориулсан төсөв мөнгөө батлаад, асуудлаа шийдээд явдаг. Сум, орон нутаг аймаг дүүрэг орон нутгийн хариуцлагыг бас нэмэгдүүлж байгаа ийм хууль. Одоо бол зөвхөн сургууль, сургуулийн захирал энэ хүмүүс хариуцлага хүлээгээд байгаа бол энэ сургуулийн орчныг сайжруулаагүйгээс үүсэж байгаа асуудалд тухайн аймаг, орон нутгийн захиргаа хүртэл хариуцлагаа хүлээдэг тогтолцоотой болж байж бид нар өнөөдөр хүүхдүүдээ эрүүл, аюулгүй орчинд сургах, эрүүл ирээдүйг бий болгох энэ боломж бүрдэнэ.

Бид нар ер нь хүүхдүүдийнхээ эрүүл мэндийн төлөө эрүүл чийрэг бие бялдартай, оюун санаатай, эрдэм мэдлэг боловсролтой ирээдүйг бүтээхийн тулд мөнгө зарцуулахгүй бол өөр юунд мөнгө зарцуулах вэ гэдэг бас их чухал асуудал шүү. Улс эх орны хөгжлийн үндсэн тулгуур бол эрүүл саруул бие бялдартай, эрдэм мэдлэгтэй залуучууд шүү. Тэгэхээр энэ дээр бас ажлын хэсгээс яг төсөв, тооцоотой асуудал байвал нэмээд хариулчхаарай.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ажлын хэсэг 4 номерын микрофон.

**Б.Буянтогтох:** Гишүүний асуултад хариулъя. Буянтогтох ажлын алба. Манай хуульд бол ерөнхий үзлэг болоод тусгайлсан үзлэг гэдэг ангиллаар үзлэг оруулсан байгаа. Тэгэхээр 1 дүгээр анги, 5 дугаар анги, 10 дугаар анги дээр үзлэг хийнэ.

Тэгэхээр тухайн жилдээ бол 220 орчим мянга орчим хүүхэд үзлэгт хамрагдахаар байгаа. Тусгайлсан үзлэг дээр. Эрүүл мэндийн салбар бол эрт илрүүлгийн ийм цогц тогтолцоо явж байгаа. Сургуульд суурилсан тогтолцоо гэдэг талаасаа Эрүүл мэндийн сайдын тушаал болоод ЭМДҮЗ-ийн тогтоол гарна. Тэр дээр гарсан тооцооллоор бол 5 орчим тэрбум төгрөг жилдээ 220 орчим мянган хүүхэд үзэхэд төсөв гарна. Энэ мөнгө болбол ЭМД-ын сангаасаа гарахаар төлөвлөгдөөд явж байгаа. Түрүүн манай гишүүн ярьчихсан. Бусад хатуу дэд бүтэцтэй холбоотой юунууд бол .../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Наранбаатар гишүүн тодруулъя.

**Н.Наранбаатар:** Ер нь бол ойлгомжтой. Асар их төсөв хөрөнгө гарна. Энийгээ маш сайн тооцоод ингээд жил болгон, эхний жилд нь хашааг нь хайсыг нь жигдлээд, дараагийн жилд нь тоглоомын талбай гээд ингээд үе шаттай явах байх. Тэгээд сум, сумын байдаг юм уу, аймаг, аймгийн иргэдийн Хурал нь зохих төсвүүдийг нь тавих, улсын төсөв дээр тавих гээд ажил их бий байх гэж бодож байна. Нэлээн хэдэн жилийн ажил болох байх.

Энэ хууль дээр сая танилцуулгаас сонссон. Үе тэнгийн дээрэлхлийг бууруулах чиглэлээр ямар зохицуулалт байгаа юм. Ямар тогтолцоо байгаа юм. Хэн хариуцах юм. Яаж мэдээллээ авах юм. Ямар хариуцлага хүлээлгэх юм. Яаж бууруулах юм гээд. Энэ талаар тодруулга авъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяагийн урилгаар Орхон аймгийн Эмпати сургуулийн багш нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багш нартаа сурган хүмүүжүүлэх их үйлсэд нь өндөр амжилт хүсье.

4 номерын микрофон.

**Б.Буянтогтох:** Гишүүний асуултад тодруулж хариулъя. Тэгэхээр Хүүхэд хамгааллын тухай хууль дээр бол яг үе тэнгийн дээрэлхэлтэй холбоотой суурь зохицуулалтууд орсон. Тэгэхээр манай энэ сургуулийн орчин дахь эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хууль бол энэ суурь зохицуулалтыг илүү яг амьдрал дээр хэрэгжүүлэхэд дэмжлэг болж оролцохоор орж байгаа. Сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой бүтэн бүлэг, 10-аад заалтаар оролцож байгаа. Тухайлбал үе тэнгийн дээрэлхэлд өртсөн байх хүүхдийг илрүүлэх судалгааны асуудал байгаа. Бас

ярилцлагын асуудлаар ингээд илрүүлээд, цаашдаа энэ илрүүлсэн байдал дээрээ түшиглээд, арга хэмжээ авахаар илүү процессжуулж оруулж өгсөн байгаа хууль дээр.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сүхбаатарын Эрдэнэбат.

**С.Эрдэнэбат:** Маш чухал хууль. Тэгээд 1 зүйлийг асуумаар байна. Сургуулийн орчин дахь эрүүл мэнд, аюулгүй байдал гээд. Яг энэ хууль дээр энэ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй чиглэлээр би бас олон жил бас явж байсны хувьд хэлэхэд яг энэ чиглэлээр энэ хууль дээр хэн зөвлөсөн бэ. Ямар судалгаа авсан бэ. Багш ажилчид, хүүхдүүд болон орчны хүмүүсээс хэр зэрэг зураг авалт хийсэн бэ гэдэг зүйлийг бол асуумаар байна.

2 дугаарт маш энгийн зүйл юм. Бид нар яах вэ, том том хууль батлахаас гадна хэрэгжилт гэдэг юмаа яг тэр чигээр нь хаячхаад байна. Бүх сургуулиудыг аваад үзэхэд будсан хананых нь будгаас хар тугалганы орц зөвшөөрөгдөх хэмжээнээс 50 дахин хүртэл өндөр байгаа. Бид нар сургуулийн барилга байшин хийхэд хамгийн хямдхан будгаар, хамгийн хямдхан зардал, шохойгоор хийчихдэг. Энэ чинь өөрөө эргээд шууд тэр хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд заналхийлж байгаа юм. Тэгээд энэ тал дээр хэрхэн хууль дээр тусгасан бэ гэдгийг асуумаар байна.

Сая чуулганы завсарлагаагаар нэлээн олон сургуулиудаар яваад анзаарч байхад хүүхдүүдээс асуухаар маш бүгчим байна гэж байгаа юм. Маш бүгчим. Цонхыг нь дандаа ингээд нэвт салхилдаг байдлаар ингээд онгойлгочихсон. Харахад маш жижиг юм шиг мөртөө хүүхдүүд байнгын агаарын дутагдалд байдаг. Үүнээс болоод хүүхдүүдийн эрүүл мэндэд маш сөрөг нөлөөтэй зүйлүүд учирч байгаа талаар бол энэ судалгаанууд гарчихсан байна. Ядаж тэр цонхыг нь тэр шууд нэвт салхилдаггүй, хамгийн захын хүүхэд шууд салхинд өртөхгүйгээр зохицуулчхаж болдоггүй юм уу. Тэгээд би энэ талаар удаа дараа саналууд хэлж байсан. Энийг Наранбаяр сайдад хэлж байсан. Одоо хэрэгжүүлэх гэж байсан ингээд больчих шиг боллоо. Дараа дараагийн сайд нар анхаараарай.

Жижиг юм мөртөө нэг их том том хууль батлаад, маш жижиг юмнууд дээрээ огт тоохгүй хаяад байх юм бол зүгээр яг ний нуугүй хэлэхэд нэг цаасан дээр бичсэн хууль болно гэдгийг бол хэлмээр байна.

Ширээ сандлын хувьд ч гэсэн аваад үзэхэд хүүхдүүд өндөр нам янз янз байдаг. Яг ижилхэн өндөртэй ширээ сандлууд тавьчихсан. Энэ чинь хүүхдийн биеийн өсөлтийн юунд бол сөргөөр нөлөөлдөг юм. Бүх ангиудыг харж байхад ганцхан хаалгатай байгаад байгаа. Аюул осол тохиолдсон тохиолдолд ганцхан аваарын хаалгатай. Өөрөөр хэлбэл аваарын хаалга гэж зүйл байдаггүй. Тэгэхээр сүүлийн үеийн барилга байшингууд дээр барилгын стандартуудыг тодорхой тавьж өгсөн зүйлүүд байна уу, үгүй юу. Энийг хууль дээр бараг шууд тавиад өгчихмөөр юм байна лээ. Сургуулийн барилгыг ийм ийм зүйл дээр нь стандарт шаардлагыг хангана гэсэн байдлаар.

Тэгээд ирээд сургуулийн орчинд аюулгүй байдлыг сахиулж байгаа хүнийг хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлын ажилтан гээд бөөн юм болж байж сая хөдөлмөр, аюулгүй байдлынх нь асуудал хариуцсан хүнд нь хариуцуулаад, цалингийн нэмэгдлийг нь олгосон. Тэгээд сургуулийн захирал хариуцна гэж байгаа.

1 сургуульд ойролцоогоор 6 мянган хүүхдийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг хариуцаж байгаа. Ганцхан ажилтан хариуцна гэдэг бол энэ бол үнэхээр хэцүү. Тийм учраас энэ сургуулийн орчин дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийг бие даасан бүтэцтэй, мэргэжлийн багтай, эрсдэлийн үнэлгээг нь хийж өгдөг энэ зүйлийг нь бол жил тутам үзлэгийг нь хийдэг ийм зүйлүүдийг нь тавьж өгөх ёстой юм гэдгийг бол хэлмээр байна.

Тэгээд ийм зүйлүүд туссан уу, үгүй юу гэдгийг асуумаар байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэн хариулах вэ. Ажлын хэсэг 4 номер.

**Д.Нарансүх:** Нарансүх ажлын хэсгийн гишүүн, судлаач. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар шаардлагыг хуульд оруулах энэ судалгаа талаас нь бол миний бие бас хариуцаж ажилласан. Боловсролын тухай хууль тогтоомжууд дээр сургуулийн орчинд хүүхэд суралцах үедээ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг бол Боловсролын тухай хууль тогтоомжуудаар тогтоож өгсөн байдаг. Тэгэхээр энэ шаардлагуудыг бол хууль дээр маань нарийвчилж тусгасан.

Хуулийн хэрэгжилттэй холбоотой сургууль дээр хийгдэх ийм үнэлгээнүүдийн хүрээнд зөвхөн хүүхдийн төдийгүй тухайн сургуулийн ажилтны эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлийн агуулгууд бол энэ үнэлгээнд бас хамрагдахаар заагдсан байгаа.

Хуулийн төслийн 20 дугаар зүйл дээр сургуулийн орчинд тавигдах шаардлагыг бол тодорхойлж өгсөн. Тэгэхээр Монгол Улсад бол 19 сургуулийн орчны барилгын норм дүрэм болон эрүүл ахуйн стандартууд байдаг. Тэгэхээр хууль бол ерөнхий шаардлагыг нь тогтоож өгөөд, энэ стандартуудын хэрэгжилтийг хангуулах талаар зохицуулалтууд орсон.

Мөн сургуулийн орчинд түрүүн гишүүний дурдсан дэгдэмхий органик хортой нэгдлүүд болон хар тугалга зэрэг материалуудыг хүүхдийн эрүүл эрүүл мэндэд аюултай материалуудыг барилгын засварт ашиглахгүй байх талаарх зохицуулалтууд маань хуулийн 23 дугаар зүйл дээр бол барилгын засварын үед тавигдах, засвар үйлчилгээ хийхэд тавигдах шаардлагуудыг мөн тодорхойлж өгсөн. Энэ талаар мөн хууль боловсруулахын өмнөх үндэслэл судалгаанууд дээр бол бас хийсэн тоо баримтууд байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номерын микрофон.

**Д.Нарансүх:** Хариулж дууслаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Эрдэнэбат гишүүн тодруулъя.

**С.Эрдэнэбат:** Яах вэ, хууль дээр тусгасан гэхээс би түрүүн асуусан шүү дээ. Барилгын хууль дээр угаасаа байгаа. Хар тугалгатай оролцоотой, хүүхдийн эрүүл мэндэд хортой тэр будгийг хүүхдийн орчинд хэрэглэж болохгүй гэсэн. Гэхдээ бодит байдал чинь өнөөдөр ингээд сургуулиудын дээжийг аваад ингээд үзэхээр тийм хэмжээний судалгаа гарчхаад байна шүү дээ. Тийм учраас одоо энийг яах вэ гэдэг асуудал дээр хуулийнх нь хувьд тодорхой заалт байна уу.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номер.

**Д.Ганхүрэл:** Ажлын хэсгийн гишүүн, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш Ганхүрэл байна. Гишүүний асуултад хариулъя. Одоогийн норм стандарт дагаж мөрдөөгүй тохиолдолд хариуцлагажуулахтай холбоотой зохицуулалт одоогийн хууль тогтоомжид бид нар судлаад үзэхэд бол олдоогүй, байгаагүй.

Зөрчлийн хууль дээр ч гэсэн Боловсролын хууль тогтоомжтой холбоотой бас зөрчил үүсэхтэй холбоотой зохицуулалт байсан. Тэр хууль нь бол одоогийн энэ багц хууль батлагдахаас өмнөх хууль хэвээрээ байгаад байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл зөрчлийн хуулиар ч гэсэн хариуцлага ноогдуулах боломжгүй болж байгаа. Тэгээд энэ хуулийн төслөөр бас дагалдан батлагдах хуульд бол Зөрчлийн тухай хууль орж ирж байгаа. Тэгээд тэр Зөрчлийн тухай хуулиараа дамжуулаад энэ норм стандарт хангаагүй сургууль, хариуцсан албан тушаалтан дээр хариуцлага ноогдуулах энэ хариуцлагажуулах зохицуулалт бол шинээр бий болж орж ирж байгаа. Мөн нөхөн төлбөртэй холбоотой асуудал дээр бас норм стандартаа хэрвээ хангасан тохиолдолд ямарваа нэгэн байдлаар бас нөхөн .../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Аюушийн Ариунзаяа гишүүн.

**А.Ариунзаяа:** Анхдагч хууль. Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай гээд. Тэгээд бид нар ямар ч байсан энэ хуулийг дэмжээд явах нь зүйтэй. Анхдагч хууль учраас энэ хуулийг бас зүйл заалтуудыг нэмэх, илүү сайжруулах энэ боломж нь бол байгаа юм. Тэгэхээр яг энэ маш том нэртэй буюу сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай гэж байгаа мөртөөсөө зөвхөн эрүүл мэндийн талаасаа буюу энэ кабинет тохижилт, тэгээд л Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн сайд тухайн журмыг батална. Сургууль бүр эрүүл мэндийн боловсрол олгох танхимтай байна. Тусгай хөтөлбөртэй байна гэсэн л нэг иймэрхүү урьдчилан сэргийлэх төлөвлөгөөтэй байна гэх зэрэг нэг л тийм салбарын л хууль болчихоод байна л даа. Гэтэл яг уул шугамдаа бол яг энэ сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдал бол цогцоор нь бид нар нэгтгэх ёстой асуудал бол мөн үү мөн. Тэгэхээр энийг бол сайжруулаад явах хэрэгтэй. Яг энэ хэлбэрээр нь байх юм бол нэрийг нь эсвэл өөрчил. Зөвхөн эрүүл мэндийн мэдлэг боловсрол олгох гэдэг юм уу ингэж явах ёстой болчихно.

Үе тэнгийн дээрэлхлийг бол хүмүүс маш их ярьж байгаа. Үе тэнгийн дээрэлхэл Монгол Улсад яг хүүхдийн хувьд бол 6 хуулиар зохицуулагдаж байгаа. Яг одоо Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, мөн түүнчлэн Боловсролын ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль, олон улсын эрх зүйн бичиг баримтын хувьд Хүүхдийн эрхийн конвенц гэх зэрэг ийм их цаас бол ер нь байгаа байхгүй юу. Байгаа. Тэгээд цаас боловсруулаад эргээд энэ асуудал огт шийдвэрлэгдэхгүй байгаа. Тэгээд яагаад шийдвэрлэгдэхгүй байгаа гээч. Томчууд өөрсдөө энэ үе тэнгийн дээрэлхэлтэй бас зүгээр энгийн юм гэдэг ийм ойлголтыг нийгэмд өгчхөөд байгаа байхгүй юу. Ээж аав нь хоорондоо зодолддог бол эсвэл аав нь ээжийг нь зоддог бол тухайн хүүхэд яах юм. Хүчирхийллийн дэргэд өсөж байгаа биз дээ. Бүхнийг хүчээр шийддэг юм байна гэсэн ойлголттой. Тухайн хүүхдийн хүмүүжлийн асуудал. Үндэсний статистикийн хороо, НҮБ-ын хүүхдийн сантай хамтраад 5 жил тутам хүүхэд хөгжил, судалгаа явуулдаг. Монголчууд одоог хүртэл хүүхэд хүмүүжлийн аргыг биеийн шийтгэлээр хүүхдээ сургадаг тохиолдол цөөнгүй, дийлэнх олонх нь тийм байгаа. Тэгээд

хүүхдийг болохгүй юм хийхээр нь хүчээр сургадаг мөртөөсөө эргээд нөгөө хүүхэд хүчээр л шийднэ гэсэн ийм ойлголттой байгаа бол аливаа асуудал тулгарлаа. Хүчтэй нь хүчгүйгээ дээрэлхэж, зоддог, дээрэлхдэг ийм байгаа.

Төрийн ордондоо хүртэл үе тэнгийн дээрэлхлийг хийж байгаагаа та нар өөрсдөө ойлгохгүй байна уу. Тэгээд хүүхдүүдээсээ бид нар ийм асуудлыг нэхээд байгаа шүү дээ. Томчууд өөрсдөө үлгэрлэлээ тэгвэл яаж харуулах юм. Энэ дээр анхаарах шаардлагатай. Тэгээд хүүхдүүддээ бид нар өөрсдөө анхаарах ёстой. Бид нар маш их хуулийг гаргаж байна. Хүүхдийн үдийн хоолны асуудал бид нар хуулийг нь гаргачихсан. Одоо хүртэл хэрэгжихгүй байгаа шүү дээ. Хүүхдүүд маань бэлэн гоймон идэж байна. Сургуулийн орчны ойрхон 150 метр дотор архи, тамхи хүүхдэд газтай ундаа билүү юу билээ нөгөө жагсаалтыг Эрүүл мэндийн сайд баталдаг байх аа. Тухайн үедээ Мөнхсайхан сайд бид нар ковидын үед ажиллаж байхад яг энэ асуудлыг журмаа шинэчлээч ээ гээд өөрөө болдоггүй юм байна. Хэцүү юм байна гэдэг ийм асуудалтай тулгарч байсан. Яагаад гэвэл бизнесүүд бусад энэ 8 нэрийн барааны дэлгүүр, энэ их ойрхон ойрхон баригдсан байр. Гаргасан хуулиа журмаа бид нар өөрсдөө хэрэгжүүлж чаддаггүй. Тамхины тухай хууль байна. Сургуулийн орчинд хүүхдийн нас баралтын 4 тохиолдол тутмын 1 нь үе тэнгийн дээрэлхлээс гэж яг юу ярчхав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэн хариулах юм. Мөнхсайхан гишүүн.

**Т.Мөнхсайхан:** Ариунзаяа гишүүнтэй бас зарим зүйл дээр санал нэг байна. Одоо цаас бол үнэхээр их байна шүү дээ. Норм стандарт бол их байна. Тийм норм стандартыг биелүүлэхгүй, хангахгүй бол ер нь хэн хариуцлагагүй хүлээх юм бэ гэдэг процессын чанартай зохицуулалт нь ерөөсөө байхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ хууль бол илүү их процессын чанартай. Энэ хүүхдийн эрүүл, аюулгүй байдлыг үүсгэсэн энэ стандартыг хангаагүй тохиолдолд хэн, ямар хариуцлага хүлээх юм бэ гэдэг зүйлийг бид нар их тодорхой болгож өгч байгаа юм.

Тэгээд энэ хууль 1 бүлэг нь эрүүл мэнд, 3 дугаар бүлэг нь аюулгүй байдал гэж байгаа. Энэ хууль дээр бид нар сургуулийн орчинд, хүүхдэд ер нь аюулгүй байдал, өвчлөл талаасаа ямар эрсдэлүүд учирч болох вэ тэр бүхнийг бид нар зохицуулахыг хичээсэн. Тэгэхээр энэ дээр бас зарим нэгэн учир дутагдалтай, нэмж хасах шаардлагатай ийм зүйл заалт бас байж болно. Энийг бол дараа дараагийнхаа ажлын хэсгүүдээр шийдээд явах боломжтой байх гэж бодож байна.

Тэр түрүүний тоо сургуулийн орчинд нас барсан 4 хүүхдийн 1 нь үе тэнгийн дээрэлхэлтэй холбоотойгоор нас барсан байна гэдэг ийм тоо. Гэхдээ энэ яах вэ, сүүлийн 4 жилийн хугацаанд аваад үзэхэд сургуулийн орчинд 4 хүүхэд л нас барсан байгаа. Энэ 4 хүүхдийн 1 нь үе тэнгийн дээрэлхэлтэй холбоотой. Гэтэл энэ сургуулийн орчинд хүүхэд очоод амь насаа алдах нь битгий хэл, эрүүл мэндээрээ хохирч болохгүй шүү дээ. Гэтэл өнөөдөр сургуулийн орчинд очоод та бүхэн мэдэж байгаа. Өнгөрсөн хугацаанд биеийн тамирынхаа талбай дээр, эрүүл чийрэг бие бялдартай болох гээд биеийн тамирын талбай дээр хичээллэж байгаа шүү дээ.

Тэгээд хөл бөмбөгийнхөө батааранд даруулаад амь нас нь эрсэдчихдэг. Өнгөрсөн жил гарсан шүү дээ. Өвөрхангай аймагт бас зааланд тоглож байгаад волейболын торны шонд дарагдаад амь насаа алдчихдаг. Эд нар бол хэвийн үзэгдэл биш шүү дээ. Энийг бид нар засаж залруулах зайлшгүй шаардлагатай.

Хамгийн гол нь ийм стандарт шаардлага хангахгүй, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлээгүй ийм сургуулиуд шинээр ашиглалтад бас ороод байгаа юм. Тэгэхээр бид нар ядаж шинээр баригдаж байгаа сургуулиудынхаа эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлж, хүүхдүүд сурч боловсрохоор очсон тэр орчин нөхцөлдөө сургууль дээрээ амь нас, эрүүл мэндээрээ хохироод байдаггүй ийм шинэ сургуулиудыг барьж байгуулах ёстой. Хуучин баригдчихсан байгаа энэ сургуулиудаа бид нар жил бүр төлөвлөгөөгөө гаргаад алхам алхмаар сайжруулах ёстой. Өнөөдөр бол жил ирэх тусам энэ орчин нөхцөл муудаад байгаа юм. Тийм учраас энэ хуулийн зайлшгүй хэрэгцээ шаардлага байна гэж үзээд байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ариунзаяа гишүүн.

**А.Ариунзаяа:** 4 хүүхэд тутмын 1 нь гэж ярих нь их том тоо байсан байна гэдгийг сая хэлчихлээ шүү дээ. Үндсэндээ бол 4 л хүүхэд байсан байна. 1 нь гэж бас хэлж байх шиг байна. Гэхдээ бас худлаа бас биш. Тэгэхээр яг тоотой бол болгоомжтой харьцдаг. Тоон дээрээ ажилладаг баймаар байна. Ялангуяа энэ тоонууд бол Эрүүл мэндийн хөгжлийн төв яг энэ нас баралт, шалтгаан, газарзүйн байршлаар нь бас гаргадаг. ЦЕГ бас гаргадаг. Тэгээд бид яг энэ сургуулийн орчинд яг энэ гэмтэл осол, нас баралтыг бол яг тухайн тоонууд дээр нь суурилж даалгавруудаа зөв өгдөг, энэ дээрээ суурилоод бас хариуцлагыг нь сайн үүрүүлж, тооцдог байх хэрэгтэй байна. Ялангуяа бас Энхнасан гишүүн яг энэ хуулийг санаачилж байгаа шиг санаад байна. Зам тээврийн осолд өртөж байгаа хүүхдүүдийг томчуудад нь хариуцлагыг нь чангаруулах энэ маш зөв. School police хийж байгаа ээж аавуудыг зодоод байж болохгүй шүү дээ. Бусад одоо .../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хэллээ. Отгоны Саранчулуун.

**О.Саранчулуун:** Сургуулийн орчин дахь дээрэлхлийн асуудлыг хөндөж байна. Тэгээд дээрэлхлийг одоо байгаа хуулийг харахаар хүчирхийлэл, ялгаварлан гадуурхлаас хамгаалах үүрэг нь сургууль болон багшид угаасаа байгаа. Одоо байгаа хуулиуд дээр. Хүүхэд хамгааллын хууль дээр байгаа. Зөрчлийн тухай хууль дээр ч байгаа. Сэтгэцийн эрүүл мэндийн хуулийн заалтууд дээр ч гэсэн байгаа. Тэгсэн хэр нь л сургуулийн орчинд хүүхдүүд дээрэлхэлд өртөөд ийм асуудал байгаа. Тэгэхээр энэ хуулиар ямар шинэ механизм тогтолцоог, хэрэгслийг бодлогын хувьд, хууль, эрх зүйн хувьд хэрэгжүүлж байж, энэ дээрэлхэл чинь тэгээд буурах юм бэ гэдэг тэр шийдлийг нь би сонирхоод байгаа байхгүй юу. Тэгэхээр яг тэр шийдэл дээр зурсан зураглал юу байгаа вэ гэдгийг чинь сонсоод, тэгээд би бас тодруулмаар байна. Яг энэ дээр.

2 дахь асуулт нь сургуулийн орчин дахь осол гэмтлийн тухай бид нар ярьдаг. Гэтэл зуны амралтаар сургууль амрах үеэр маш олон хүүхдүүд хүүхдийн зуслан, хөгжлийн бэрхшээлтэй сургуульд явж чаддаггүй хүүхдүүд дэмжих төвүүдээр, өдөр өнжүүлэх гээд маш олон байгууллагууд байгаа. Тэнд бол маш олон хүүхдүүд бас л адилхан боловсролын сурах, хөгжих үйлчилгээг авдаг. Тэр газрын эрүүл мэндийн асуудал, дээрэлхлийн асуудал, орчны асуудлыг ямар хууль, эрх зүйн хүрээнд авч үзэж хамгаалах юм бэ. Нэгэнт л анхдагч шинэ хууль хийж байгаа бол хүүхдийг сурах орчинд нь аюулгүй байлгах гээд байгаа концепц ярьж л байгаа юм бол саяын миний хэлсэн байгууллагуудыг авч үзэхгүй юм уу гэдэг дээр тайлбар сонсьё. Тэгээд тодруулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Мөнхсайхан гишүүн.

**Т.Мөнхсайхан:** Бид нар яриад байгаа. Бид нар энэ үе тэнгийн дээрэлхэл гарсан даруйд нь л бөөн сенсац болоод, тэгээд л орхидог. Тэгээд бид нар гарсных нь дараа ямар арга хэмжээ авах гээд байгаа юм, хариуцлага тооцох гээд байгаа гэдэг зүйлийг бусад хуулиудаар зохицуулсан байгаад байгаа юм. Гэтэл энэ үе тэнгийн дээрэлхлээс хэрхэн, яаж урьдчилан сэргийлэх юм бэ гэдэг ийм зохицуулалт хаана ч, ямар ч хууль дээр байхгүй байгаад байгаа. Тэгэхээр манай энэ хууль дээр сэтгэл зүйн зөвлөгөө гэдэг тусдаа тийм хэсэг байгаа. Тэр дээр жил болгон үе тэнгийн дээрэлхэл үүсэж болзошгүй ямар нөхцөл байдал үүсээд байгаа юм бэ. Байнгын судалгаагаа авах ёстой.

2 дугаарт энэ эрүүл мэндийн баг гэдэг зүйл дээр ямар нэгэн нэмж албан тушаалтан байхгүй. Сургуульд байдаг яг албан тушаалтнууд, дээрээс нь эцэг эхийн төлөөлөл, сургуулийн төлөөлөл орсон энэ баг маань үе тэнгийн дээрэлхлээс хэрхэн яаж сэргийлэх ёстой юм бэ. Яаж мэдээ мэдээллээр хангах ёстой юм бэ гэдэг энэ төлөвлөгөөг боловсруулаад, энийгээ аймаг, орон нутаг, дүүргийнхээ удирдлагуудтай хамтарч батлаад, энийгээ байнгын хэрэгжүүлж, энэ үе тэнгийн дээрэлхлээс сэргийлэх асуудлыг бид нар байнгын тогтмол хийж хэрэгжүүлдэг, илрүүлдэг энэ тогтолцоог л бий болгохын тулд энэ хуулийг санаачлаад хэрэгжүүлээд байгаа юм. Манай ажлын хэсгээс нэмээд хариулчих.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номерын микрофон.

**О.Чимидсүрэн:** Саранчулуун гишүүний асуултад нэмэлт тодруулга өгье. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 900 ерөнхий боловсролын сургуульд өнөөдрийн байдлаар сэтгэл зүйч 580 ажиллаж байна. 305 сургууль нь сэтгэл зүйчгүй байна. Нийгмийн ажилтан нь 953 ажиллаж байгаа боловч 80 орчим хувь нь сургуулийн нийгмийн ажилтан биш байна. Өөрөөр хэлбэл хуульд эрүүл мэндийн багийг цогцоор нь бий болгосноор энэ үе тэнгийн дээрэлхлээс сэргийлэх, өөрөөр хэлбэл гараад байгаа bullying бол хамгийн эцсийн цэг дээрээ гараад байгаа. Тэгэхээр үе тэнгийн дээрэлхэлд хэн өртөж байна. Энэ хүүхдүүддээ эрүүл мэндийн боловсрол олгох, тандах, илрүүлэх, илэрснийгээ сэргийлэх, гэр бүлтэй нь ажиллах гэдэг цогц зохицуулалтыг хийж өгснөөрөө үе тэнгийн дээрэлхэл гарахаас нь өмнө суурь сэргийлэлт, анхдагч сэргийлэлтийг хийгээд, энийг таслан зогсоох чиглэлийн ажлууд хийгдэж, хуулийн үр дүнд хүрнэ гэж харж байгаа.

Өөрөөр хэлбэл мэргэжлийн баг байхгүй учраас .../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Саранчулуун гишүүн.

**О.Саранчулуун:** Би байна шүү дээ. Хууль яагаад хэрэгтэй байгаа тухай ойлгож байгаа. Одоо тэр мэргэжлийн цогц баг байхгүй байгаа гэдгийг ойлгож байгаа. Сургуулиудад сэтгэл зүйч байх ёстой, нийгмийн ажилтан байх ёстой гэдгийг бид нар аль 10 жил гаруйн өмнө яриад, өдий хүрээд явж байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр байсаар байхад ажиллахгүй байгаагийн чинь шалтгаан нь хүнгүй болоод байгаадаа юм уу. Эсвэл нэг санаачилгатай захирал нь тэр сургуулийн дээрэлхлийн эсрэг бодлого гаргаж чаддаггүйдээ юм уу гэдэг асуудлыг л яриад байна л даа. Одоо угаасаа байгаа бүтцийг шинэ төлөвлөгөө гаргах хэмжээнд авчрах гэж байгаа юм бол

бүхэл бүтэн анхдагч хууль гаргаад яг юунд, ямар ахиц гаргах гээд байгаа юм. Хэрвээ анхдагч хууль ярьж л байгаа бол арай жоохон ахисан түвшинд ярья л даа.

Хүүхдүүдийн сурах орчин дотор чинь түрүүний миний хэлсэн хүүхдийн зуслан, өдөр өнжүүлэх, дэмжих төвүүд бүгдээрээ орно шүү дээ. Тэд нарыг асуухаар ерөөсөө хариулахгүй байгаа байхгүй юу даа. Тэд нар энэ тэр чинь сурах орчиндоо орно биз дээ. Тэрийг нэмээд явах хэрэгтэй юм биш үү энэ анхдагч хууль дээрээ гэдгийг л яриад шүү дээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номерын микрофон.

**О.Чимидсүрэн:** Хуулийн хэлэлцүүлэг явж байгаа учраас энэ хууль илүү процессын шинж чанартай хууль. Анхдагч хууль хэдий ч тэгэхдээ энд дутуу зүйл байгаа бол Их Хурлын эрхэм гишүүдийн саналаар дахиж нэмэгдэх боломж бол нээлттэй байгаа гэж харж байгаа. Сургуулийн орчин гэдэг рүү энэ хууль маань эхний удаад нэлээн төвлөрч байна. Хэдийгээр тийм эрүүл мэндийн баг хуульчилчихсан хэр нь одоо ажиллаж үр дүнд хүрэхгүй байгаа учраас энийг сургуулийн эрүүл мэндийн бодлогоор зохицуулах юм. Таны хэлээд байгаа тэр бүх заалтуудыг яг журам шиг хуульд оруулах боломжгүй. Тэгэхээр энэ хууль дээр төлөвлөгөө, бодлого гэдэг заалт руу энэ илүү уялдах юм. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дашдондогийн Ганбат.

**Д.Ганбат:** Гишүүд бас ийм хууль санаачлаад явж байгаа нь сайн байна. Энэ бол бас л ярилцах ёстой асуудлуудын 1 л дээ. Өнөөдөр бас Засгийн газар бол хэвийн ажиллах боломжтой. Мэдээж хэрэг үүрэг гүйцэтгэгч сайд нар гэж байхгүй. Гэхдээ бид нарын нөгөө яриад байдаг, ад үзээд байсан дэд сайд нар бол байгаа байх. Боловсролын дэд сайд байгаа байлгүй дээ. Энийг бас асуугаад, хариулаад явах боломжтой гэж үзэж байна.

Ер нь Монгол Улсын хэмжээнд эрүүл аюулгүй, шаардлага, сурах боломж энэ тэрийг нь хангачихсан сургууль байна уу. Би 1 л сургууль мэднэ. Бусад нь бол шаардлага хангахгүй. Таны хариулсны дараа би тэрийг нь хэлж өгнө. Нөгөө талаар бол одоо хүнд байгаа шүү дээ ер нь бол. Манай сургуулийн орчин, тэндээс явж байгаа сургалт энэ тэр гээд л. Тэгээд сүүлийн үед ер нь олигтой Боловсролын сайд тавигдсан юм уу. Өөрсдөө л Боловсролын зээлийн сангаас мөнгө төгрөг авахаа л мэдэх юм. Хүүхдэдээ өгөхөө мэдэх юм. Ийм л маягтай байгаа шүү дээ. Танд энэ хууль санаачилсан хүмүүс судалгаа явуулж үзэв үү.

Жишээлбэл, бид нар хууль батлах гээд сууж байгаа Улсын Их Хурлын 126 гишүүний хүүхдүүд нь хаана ямар сургуульд сурдаг юм. Өмнө хуучин Ерөнхий сайд байсан Оюун-Эрдэнийн хүүхдийг хаана сурдгийг би хэвлэлээс харсан л даа. Лондонд сурдаг юм байна лээ шүү дээ. Тэгээд тэр хөл бөмбөгийн багийг нь янз бүрийн мөнгөөр соёлын яамнаас санхүүжүүлдэг л юм билээ. Өнөөдөр шаардлага хангасан хөл бөмбөгийн талбайтай сургууль байгаа юу. Тэгэхэд Сөүл гээд л бид нар очиход, энэ Хятад энэ тэр чинь гаднаа бүгдээрээ хөл бөмбөгийн талбайтай шүү дээ. Тэр эрүүл ахуйн шаардлага хангасан. Монгол Улсад газраас их юм байхгүй. Бид нар боловсролдоо, хүүхдүүддээ ингэж л хандаж байгаа байхгүй юу. Хамгийн наад захын шаардлага гэхэд 12 наснаас доош хүүхдийг гэртээ ганцааранг нь орхиж болохгүй. Манайд тийм юм байхгүй. Тэр тэгээд галд түлэгдээд л. Тэр хоол ундыг нь хар.

Хамгийн муу хоол ундаар, шим тэжээлгүй ийм хоол ундаар хүүхдүүдийг тэжээгээд л байж байгаа. Тэр ашиглаж байгаа сав суулгыг нь хар. Үнэхээр хэцүү шүү дээ. Тэгээд тэр сургууль аюулгүй орчинд барьсан сургууль байхгүй. Японд бол хамгийн аюулгүй орчин бол сургууль байдаг. Хамгийн чанартай барилгын материалаар хийдэг. Манайд тэгдэггүй. Хэдэн дарга нарын компаниуд тэр сургуулийг барьдаг. Хамгийн муу сургууль барьдаг. Хамгийн хямд хийж байгаа нэртэй ийм л бизнес болсон. Энэ дээр анхаарч байгаа юу.

Одоо тэгээд дунд сургууль төгсөөд гарч байгаа Монгол хүүхдүүдийн чанар ямар байгаа билээ. Тэр ПИСА-ийн юугаар бол бараг уншиж чадахгүй гэсэн тэр хэмжээнд хүрсэн байгаа шүү дээ. Одоо бас хар тамхины үүр болчихсон, болох гэж байгаа тийм сургуулиуд байна. Тэр талаар судалгаа байгаа юу та нарт. Энийг судалж үзэв үү. Ялангуяа хувийн сургуулиуд. Одоо бүүр хямдхан тийм таблет энэ тэр гарчихсан байна лээ. Тэрийгээ гэр хорооллын сургууль руу алдчихвал тэгээд л дуусаа. Бразилд тийм юм байна. Гита гээд үүсчихсэн. Цагдаа нь ч орж чаддаггүй ийм юмнудаа та нар үзэж харсан уу. Ямар байгаа вэ. Энэ дээр анхаарч ажиллаж чадаж байгаа.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэн хариулах вэ. Мөнхсайхан гишүүн.

**Т.Мөнхсайхан:** Гишүүний асуултад хариулъя. Эрүүл сургууль цогц үнэлгээний шалгуурыг бас АНУ-ын Өвчний хяналт сэргийллийн төвөөс гаргасан. Сургуулийн эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтүүдээр бид нар нэлээн дийлэнх сургуулиудад үнэлгээ хийсэн. Энэ үнэлгээгээр ер нь бол 930 оноо авах ёстой бол дундаж оноо авалт нь 467,3 буюу 50,2 хувийн үнэлгээ авч байгаа юм. Тэгэхээр манай улсад үйл ажиллагаа, сургах үйл ажиллагаа явуулж байгаа нийт сургуулиудын дийлэнх хувь нь стандарт норм хангахгүй байна. Хүүхдийн сургах эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлж чадахгүй байна гэдэг ийм тоо баримтууд гарч байна гэсэн үг.

Тэгэхээр ер нь яг энэ бүх норм стандартыг хангаж байгаа сургууль бол яг таны хэлдгээр бараг манай улсын хэмжээнд байхгүй шахуу байгаа. Бид нар бол судалгаанууд хийхдээ үнэхээр энэ хууль, эрх зүйн орчин үнэхээр хэрэгтэй байна уу үгүй юу хэрэгцээ шаардлагын судалгаа. Энэ сургуулиудын стандарт, норм дүрмээ хангаж байгаа байдал ямар түвшинд байгаа юм бэ гэх мэтчилэн энэ судалгаануудыг л хийсэн. Бид нарт цаашид энэ хуулийг боловсруулахад шаардлагатай энэ судалгаануудыг хийсэн болохоос биш одоо ямар нэгэн байдлаар төрийн өндөр албан тушаалтны хүүхдүүд хаана сурч байна вэ гэдэг ийм судалгаа бол бид нарын энэ хуулийн төслийг боловсруулахад ямар нэгэн ач холбогдол байгаагүй учраас ийм судалгаануудыг хийгээгүй. Ингээд ажлын хэсгээс нэмж хариулах зүйл байвал нэмээд хариулчихъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

**Д.Нарансүх:** Түрүүн Мөнхсайхан гишүүний хэлсэнчлэн судалгаа хийх, хуулийн төсөл боловсруулах явцад эрүүл сургууль цогц шалгуур үнэлгээгээр нийслэлийн сургуулиудад үнэлгээ хийсэн. Энэ үнэлгээ дээр бол сургуулийн гадаад, дотоод орчны аюулгүй байдал, хүнсний эрүүл ахуй, хүүхэд хөгжил, гэр бүлийн хөгжил зэрэг 11 шалгуур үзүүлэлтүүдээр үнэлсэн. Яг үнэлгээ хийхтэй зэрэгцээд Монгол Улсад бас яг энэ сургуулийн орчин дахь эрүүл, аюулгүй байдлын стандарт, норм дүрэм байна уу гэдгийг бас судалсан. Норм дүрэм байгаа хэдий ч сургуулиуд дээр

хэрэгжилт маш хангалтгүй байгаа нь бол үнэлгээгээр тодорхойлогдсон. Бүх 11 бүлэг үнэлгээ дээр бүх оноо бол авах ёстой онооноосоо хангалтгүй буюу муу үнэлэгдсэн.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 дүгээр сарын 1-нд төрсөн Улсын Их Хурлын гишүүн Буяагийн Тулга, өнөөдөр буюу 4 дүгээр сарын 2-ны өдөр төрсөн Улсын Их Хурлын гишүүн Отгоны Саранчулуун нартаа төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн түшээ, эрхэм түшээ ард түмний элч болсон танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Баяр хүргэе. Ганбат гишүүн тодруулъя.

**Д.Ганбат:** Яах вэ, энэ хуулийг батлах гээд сууж байгаа энэ гишүүд маань энэ юмаа ойлгосон байх ёстой гэдэг утгаараа асуусан шүү. Тэгээд ардын хүүхдийн төлөө яагаад анхаардаггүй юм бэ. Ардын хүүхдүүд яахаараа ийм байдалд байдаг юм бэ гэдэг юм чинь эндээс ургаж гарч байна л даа.

Тэр хар тамхи янз бүрийн холбоотой юман дээрээ бол хариулсангүй шүү та нар. Тэрийг хамгийн түрүүнд л харж үзэх ёстой. Нөгөө талаар бол Монгол Улс ганц л сургууль байгаа. International school of Ulaanbaatar гэж байгаа. Олон улсын дунд сургууль. Тэнд бол бассейнтай, гаднаа хөл бөмбөгийн талбайтай, тэр давхар нь 2, 3 давхар байдаг ийм л сургууль байгаа. Яг ийм сургуулиудыг олон болгох хэрэгтэй. Гэхдээ 40 хувьдаа л Монгол хүүхэд авч байна уу даа. Ийм л байдаг. Хувий сургуулиудыг бас дэмжих ёстой юм. Хувийн сургуулиуд тэр .../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Мөнгөнцагийн Ганхүлэг гишүүн алга байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн.

**Х.Баасанжаргал:** Надад хуулийн төсөлтэй холбоотой 2, 3 асуудал дээр байр суурь бөгөөд асуулт байна. Хуулийн төсөл дээр ажилласан хуульчдын баг хариулах байх, анхаарах байх гэж бодож байна.

1 дүгээрт энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй холбоотой асуудлыг энэ хуулийн төсөлд 1 бол огт оруулаагүй байна. Зарим 1 заалт дээр болохоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг энэ сургуулийн эрүүл мэндийн багт оруулахгүй гээд 6.3 дээр заачихсан байна. Энэ яагаад ингэж заасан бэ. Яг энэ эрүүл мэндийн үйлчилгээ, эрүүл мэндийн үзлэг шинжилгээ гээд энэ бүх үйлчилгээнүүд чинь яг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдэд хэрхэн хамрагдах юм. Тэдний хэрэгцээ шаардлага, онцлогт яаж уялдуулах юм гэдэг заалт ерөөсөө байхгүй байна. Тэгэхээр энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй холбоотой 1 асуулт, энэ 2 асуултад хариулаад өгөөсэй гэж бодож байна.

2 дугаарт санхүүжилтийн механизмыг харлаа. Улсын төсөв гэж тавьсан байна. Бусад хувийн аж ахуйн нэгжийн хандив тусламж гэж бас байж болохоор байна. Энэ үйл ажиллагааг хувийн эмнэлгүүд хийвэл яах вэ. Боломжтой юу. Тэгвэл улсын төсвөөс хувийн эмнэлгийг санхүүжүүлнэ гэсэн үг үү гэсэн ийм асуулт байна.

3 дугаарт анхаарал татаж байгаа нэг зүйл бол энэ сэтгэцийн эрсдэлийг үнэлэх үнэлгээ гэж хэд хэдэн газар орсон байна. Яг энэ хүүхдүүдийн аюулгүй байдал, нэр төр, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээтэй холбоотой гарч ирж байгаа шинжилгээ ямарваа нэгэн хүүхдийн хувийн эмзэг мэдээллүүд гарч ирнэ. Энэ мэдээллийг хэрхэн хадгалах, хамгаалах, энэ мэдээллийг алдсан хүнд ямар хариуцлага тооцох талаар тусгасан уу. Энэ дээр бас тодорхой хариулт өгөөч ээ гэсэн ийм хүсэлттэй байна.

Тэгээд хамгийн гол энэ хуулийн үзэл санаа, зорилго, нэр нь бол маш том байгаад байгаа. Сургуулийн орчны эрүүл мэнд таслал тавиад аюулгүй байдлын тухай хууль гээд. Тэгэхээр нөгөө аюулгүй байдал гэхээр эрүүл мэндээсээ илүү өргөн хүрээтэй байгаад байдаг. Гэтэл хууль зүйн техникийнхээ хувьд эрүүл мэндийнхээ дараа ингээд орчихсон байгаад байдаг. Тэгэхээр яг энэ хууль зүйн техник талаас нь би бас жаахан гайхаад байна л даа. Тэгээд яг доторх агуулга нь бол яах вэ тэр чигээрээ сургуулийн орчин эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд шинжилгээнд бол чиглэчихсэн байна. Тэгэхээр энэ хууль зүйн техник тал дээрээ та хэд ямар ямар хариулт өгөх вэ гээд.

Хамгийн сүүлд энэ дотуур байрны хүүхдийн асуудлууд сургуулийн орчин гэдэгт мэдээж орох байх. Гэхдээ дотуур байрны онцлогтой холбоотой бас зохицуулалт ерөөсөө ороогүй байна. Тэгэхээр дотуур байрыг та хэд маань юу гэж харж байгаа вэ гэсэн ийм асуулттай байна.

Тэгээд эцэг эхийн зөвшөөрлийг авах уг нь зохицуулалт хэрэгтэй байдаг. Гэтэл хуулийн төсөл дээрээ болохоор заавал дараах үзлэг шинжилгээнд орно гээд заачихсан хэр нь, дараагийнхаа заалт дээр эцэг эхчүүдээ эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу татгалзаж болно. Бичгээр татгалзаж болно гээд байна. Гэтэл нөгөө хөдөө, орон нутагт амьдарч байгаа, алслагдмал газар амьдарч байгаа, дотуур байранд амьдарч байгаа хүүхдүүдийн эцэг эх тэр болгон энэ асуудал дээр чинь хариулт өгч чадахгүй шүү дээ. Тэгэхээр энэ яг өөрөө цаанаа хүний эрүүл мэндийн эрхийн асуудалд ийм албадлагын шинжтэй зүйл яваад байна л даа. Тэгэхээр энэнийхээ балансыг яаж харж байгаа вэ гэсэн ийм асуулттай байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ажлын хэсэг 4 номер.

**Д.Ганхүрэл:** Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Энэ хуулийн төсөл дээр бол хүүхдийг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх зарчим бол тусгагдсан байгаа. Тэгээд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьд ч гэсэн тухайн сургууль маань өөрийн зохион байгуулалтаараа дамжуулаад, бас эрүүл мэндийн үзлэг шинжилгээ дээр орон нутгийн эмнэлгийн байгууллагын туслалцааг аваад, үзлэг шинжилгээг зохион байгуулна. Тэр утгаараа бол сургууль энийг бол зохион байгуулалтаараа шийдчих боломжтой гэж бидний зүгээс бол харж байгаа.

Тэр эрүүл мэндийн багт бага ангийн хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оруулаагүй шалтгаан нь энэ багт маань өөрөө сурагчдын төлөөлөл орж байгаа нь бас тодорхой хэмжээний хяналт оролцоо байгаа. Тэгэхээр бас тодорхой хэмжээнд бага насны хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хариуцлагажуулах ч гэдэг юм уу, энэ асуудлаас сэргийлэхийн тулд оруулахгүй байхаар бол тусгагдсан байгаа.

Хувийн сургууль дээр ч гэсэн мөн адил ялгаварлан гадуурхахгүй байх ийм зарчим явж байгаа учраас төсвийн хувьд байх юм бол ялгаагүй гэж явж байгаа. Тэгэхдээ мэдээж бас нөгөө суралцагчдын маань эцэг эхийн зөвшөөрлөөр дамжуулаад, үзлэг шинжилгээнд хамрагдахгүй байх ийм боломж бас байгаад байгаа.

Тэгээд дата хамгааллын талаар бас асууж байна. Тэр бол одоогийн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль дээр зааснаар бол орон

нутгийн байгууллага энэ датаг бүрдүүлэх, санг бүрдүүлэхтэй холбоотой журам бас холбогдох ажиллагааг хийхээр байгаа. Тэгээд энэ маань мэдээж нөгөө Хувийн мэдээлэл хамгааллын тухай хууль болон бусад мэдээлэл хамгаалах хуулиараа бол хамгаалагдаад байна.

Дотуур байрны асуудал бол таны хэлсэнчлэн яг үнэн сургуулийн орчин гэдэгтэй бол хамаарч байгаа. Тэгээд дотуур байрны бас тусгайлсан стандарт байгаа. Ер нь аягүй олон стандарт байгаа. Тэгээд энэ хуулийн зорилго бол стандарт болгон дээр ярихаас илүү ер нь нийтлэг бүхий л стандартыг хангуулах арга механизмыг хэрэгжүүлэх, тэр механизмаар хангах ийм үндсэн зорилготойгоор бол боловсруулагдсан байгаа. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баасанжаргал гишүүн.

**Х.Баасанжаргал:** Яах вэ, миний нөгөө сурагчдын сэтгэцийн эрүүл мэндийн эрсдэлийг үнэлэх, жил болгон үнэлнэ гээд. Эрсдэлтэй гэдэг сурагчдын мэдээлэл гараад ирлээ гэж бодъё. Хэн нэгэн хүүхдийн асуудал гарч ирнэ тэнд. Тэгэхээр тэр мэдээллийг хадгалах хамгаалахыг энэ дээр яг нарийвчлаад хэрвээ задрах юм бол яах вэ гэдэг хариуцлагын асуудал дээр зөвхөн нөгөө хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар зохицуулна гэж та хэд хараад байна уу. Яаралтай шуурхай авах арга хэмжээ гэж юу байх вэ. Зөрчлийн хуулиар цагдаа шалгаад, тэрийг тогтоох гэсээр байтал хүүхэд тэнд ялгаварлан гадуурхалтад өртөнө. Тэр эрсдэлийг яаж хамгаалах вэ гэж асуугаад байгаа юм.

2 дугаарт зөвхөн энэ охидод зориулаад цус багадалтын илрүүлэх шинжилгээ хийдэг нь бас ямар учиртай юм бол. Цаана нь ямар зүйл байдаг юм бол. Энэ ямар учир шалтгаан цаана нь байдаг юм бол гэсэн ийм асуулт байна.

Тэгээд хамгийн гол түрүүний хэлж байсан, миний тэр санхүүжилттэй холбоотой асууж байгаа зүйл хувийн эмнэлгийг санхүүжүүлэх үү. Энэ төсөв энэ мөнгөөр гэсэн үг. Энийг .../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номерын микрофон байна уу.

**Б.Буянтогтох:** Ажлын алба Буянтогтох. Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр үзлэгт бол манайх эрт ил илрүүлгийн тогтолцоогоороо яваад, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас сонгон шалгаруулалтад тэнцсэн хувийн эмнэлэг бол энэ үйлчилгээг үзүүлэх бүрэн бололцоотой. Одоо бол зохицуулалт нь тэгж явдаг.

Охидын үзлэгийн хувьд бол 15 настай дээр орж ирж байгаа юм. Ер нь бол олон улсад нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд гэж 15-49 настай эмэгтэйчүүдийг хэлдэг. Тэгэхээр энэ нөхөн үржихүйн насны хамгийн босго эхлэл нас болохоор эрүүл эхээс ирээдүйд эрүүл хүүхэд төрөх гэдэг утгаараа цус багадалтыг бол бага насанд нь илрүүлээд эмчлэх явдал бол маш чухал байдаг. Тийм учраас энэ агуулгаараа цус багадалтыг нөхөн үржихүйн насны босго насан дээр нь тодорхойлох нь бас чухал учраас энийг бол оруулж өгсөн байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Наранцэцэгийн Алтаншагай гишүүн.

**Н.Алтаншагай:** Тодруулах хэдэн зүйл байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэн хариулах юм. 4 номер. Хүүхдийн эрсдэлийг яаж хамгаалах талаар.

**Д.Ганхүрэл:** Мэдээллийн эрсдэл. Ерөнхийдөө бол энэ үзлэг шинжилгээг тогтмол зохион байгуулснаараа үүгээрээ дамжуулаад Монгол Улс дахь нийт хүүхдүүдийн бас эрүүл мэндийн мэдээллийг цуглуулж бүрдүүлж, тэрнийхээ дагуу хариу арга хэмжээ авах ийм үндсэн зорилготой байгаа. Нийтлэг утгаараа бол Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль бол ашиглагдана. Дата мэдээлэл тайлан гаргахдаа бол хүүхдийг тодорхойлох боломжгүй, хувь хүнийг тодорхойлох боломжгүй болгох хүрээнд л мэдээллийг бол ашиглахаар байгаа. Өөрөөр хэлбэл нийтлэг байдлаар ашиглана гэсэн үг. Өвчний үзүүлэлт болон бусад асуудлын талаар.

Тэгээд мэдээлэлтэй танилцах эрх бүхий этгээдүүд нь бол заагдаад өгчихсөн. Энэ дээр бол хүн болгон танилцах боломжгүй. Тэгээд тодорхой хэмжээний эмч ч гэдэг юм уу, эрх бүхий субъект бол танилцана. Тэгээд мэдээлэл задруулсантай холбоотойгоор бас нөгөө Хувийн мэдээллийн тухай хууль дээр байгаагаас илүү өндөр..../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Баасанжаргал гишүүн.

**Х.Баасанжаргал:** Хуулийн төслийг боловсруулсан багийнханд яах вэ, миний өөрийн маань санал шүү. Ялангуяа энэ хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах дээр онцгой анхаарахгүй бол хүүхдийн маш эмзэг эрүүл мэндийн мэдээллийг сургуулийн захирал, багш, удирдлагууд мэднэ гэсэн үг. Нэгэнт энэ мэдээлэл тэд нар мэдсэн тохиолдолд ямарваа нэгэн байдлаар ашиглагдах, ямарваа нэгэн байдлаар задрах юм бол хүүхдийн аюулгүй байдал насан туршдаа эрсдэлд орно. .

2 дугаарт охидын үзлэгийн асуудлыг энэ зүйл дээр оруулна гэхэв үү, оруулахгүй гэхэв үү. Тэр бүр маш сонин сая хариулт хэлчихлээ. Энийгээ тодруулаад, яг баталгаажуулаад хэлээд өг гэж хэлэх гээд байна.

Тэгээд хамгийн сүүлд нь тэр нөгөө хувийн эмнэлгийн асуудал, хувийн сургуулийн асуудал гээд дахиад л эрүүл мэндийн үйлчилгээг хүүхдээр дамжуулаад дахиад хэн нэгний ийм бизнесийг дэмжих юм яваад байгаа юм биш биз дээ гэдэг болгоомжлол саяын хариултаас гарчихлаа гэдгийг бас тодруулаад хэлье. Тэгээд хуулийн төслийг дэмжиж байгаа боловч нарийн энэ механизмуудаа жаахан анхаарах хэрэгтэй байна гэсэн саналтай байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал уу. Охидын үзлэгийн талаар тодруулъя гэсэн байна. 4 номерын микрофон.

**Б.Буянтогтох:** Охидын үзлэг биш, охидын цус багадалт гэдгээр орж ирж байгаа юм. Яагаад гэхээр бид нар хоол тэжээлийн үндэсний 6 дугаар судалгаа дээр охид дээр бол 40 хувь нь цус багадалттай байгаа учраас цаашдаа нөгөө цус багадалтыг энэ сургуулиар дамжуулж илрүүлэх нь бол маш чухал байгаа учраас энийг охидын үзлэг биш, охидын цус багадалтыг илрүүлэх шинжилгээ гэдэг талаасаа авч үзэж байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Наранцэцэгийн Алтаншагай гишүүн.

**Н.Алтаншагай:** Хуулийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж байгаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан бас хэдэн тодруулах зүйл байна. Хүүхдийн сургуулийн орчноос элдэв янзын халдварт өвчин, сүрьеэ, томуу, томуу төст өвчлөлөөр өвчлөх, хүүхдийн суралцах эрхэд ноцтой зөрчил үүсэж байгаа тохиолдлууд жил болгон нэмэгдэж байгаа. Тэгээд яг ид хичээлийн үеэр нь карантин тогтоогоод хаана, хаахгүй гээд ингээд асуудал үүсдэг. Яг энэ эрүүл мэндийн чиглэлээр нь бид бүхэн хамгаалж чадаж байгаа юу. Хэрэгжилт ямар байгаа вэ. Хууль дээр яаж туссан бэ. Хууль, эрх зүйтэй нь уяад санхүүгийн ямар дэмжлэгийг энэ боловсролын байгууллагад үзүүлэх юм бэ. 1 дүгээрт.

2 дугаарт энэ үе тэнгийн дээрэлхийг бүгд л ярьж байна. Ил далд хэлбэртэй байгаа. Сая нөгөө сошиал дээр гарахаар нь л шуугиад байгаа болохоос биш энэ чинь бас далд хэлбэрт байж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр яг Боловсролын яам, яг энэ хүүхдийн эрхийн байгууллагууд яг ямар арга хэмжээ авах юм бэ. Энэ хууль дээр тийм зохицуулалт байгаа юм уу. Журмаар байх юм уу, ёс зүйгээр байх юм уу.

Аюулгүй байдал гээд ярихаар маш олон зүйл яригдана. Сургуулийн орчны, боловсролын байгууллагын орчны энэ камержуулалт хяналт нэгдсэн системтэй байх юм уу. Тухайн сургууль нь яг бие дааж хариуцаад явах юм уу. 2 дугаар асуудал байна.

3 дээр энэ сургуулиудын цайны газрын, тэдгээрийн хоол, хүнс тэжээл. Өмнө нь бол энийг чинь юу хариуцдаг байсан шүү дээ. Тухайн өмчийн газрууд нь хариуцаад, тендер зарлаад сонгон шалгаруулалтаар хийдэг байсан. Одоо энийг сургуулийн захирал нь, сургууль нь өөрөө хариуцаж байгаа. Анх энэ чинь бас хэлэлцэгдээд ажил болоод эхлээд явж байхдаа сургуулийн захирал нь нярав, тогоочтойгоо дагуулчихсан Дэнжийн 100 дээр мах аваад л явж байсан шүү дээ. Тэгэхээр энэ дээр чинь ямар юмных нь эрүүл мэнд, аюулгүй байдал ярих вэ дээ. Энэ зохицуулалтыг яаж тусгах юм бэ. Тэгээд хариулт аваад тодруулга авъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэн хариулах вэ. 4 номер. Та хэд бэлдэж байгаач.

**М.Намхайринчэн:** Ажлын албанаас Мандахын Намхайрэнчин. Хуулийн тухайд бол санхүүжилт нь чиг үүргээ дагах зарчмыг бол баримтлахаар зорьсон байгаа. Ийм учраас хуулийн хүрээнд үүсэж байгаа чиг үүрэг бүр дээр санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой байдлыг бол хангахаар зорьсон. Түүнчлэн санхүүжилтийн эх үүсвэрийг бол өргөтгөсөн байгаа. Тухайлбал улсын төсөв болон орон нутгийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс бол санхүүжихээс гадна, хандив тусламж, олон улсын байгууллагын санхүүжилтээр бол санхүүжих боломжтой. Ингэхдээ өнөөгийн тогтолцоогоор бол 1 сурагчид хувьсах зардалд бол эрүүл мэндийн үйл ажиллагаа багтсан. Гэвч өнөөдөр тухайлбал 10 дугаар ангийн хүүхдэд бол итгэлцүүрээр тооцоогүй дүнгээр үзэхэд бол 4 мянга орчим төгрөг л ноогдож байгаа. Энэ бол энэ хуулиар үүсэж байгаа чиг үүрэгт бол хүрэлцээгүй байгаа. Ийм учраас үүнтэй холбоотойгоор бол санхүүжилт тус бүрийг хууль дээр яг нарийвчилсан байгаа. Тухайлбал санхүүжилттэй холбоотой 6 заалт, үүнээс ерөнхий шинжилгээг бол 1 иргэнд үзүүлэх санхүүжилтээр, тусгай шинжилгээг бол Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжихээр байгаа. Түүнчлэн сургуулийн өмнөх боловсрол эрүүл мэндийн анхан шатын үйлчилгээ бол орон нутгийн чиг үүрэг,

төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүрэгт хамаардаг учраас тухайн орон нутаг маань энэ чиг үүргээ хэрэгжүүлэхдээ зардлыг бол суурь зардалдаа тусгаад, суурь зардал мэдээж алдагдалтай аймгуудын дээд шатын төсвөөс санхүүгийн дэмжлэг авах замаар бол санхүүжүүлэх боломж нь өнөөгийн тогтолцоонд байгаа. Мөн цаашид сайжруулах санхүүжилтийн арга зам бол мэдээж байгаа байх. Энэ асуудлыг бол ажлын хэсэг дээр бас нарийвчлаад авч явах боломжтой гэж үзэж байгаа. Баярлалаа. Би санхүүжилтийн хувьд бол зөвхөн хариулж байгаа.

**Б.Оюунжаргал:** Ажлын хэсгийн гишүүн, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш Оюунжаргал байна. Тэгэхээр гишүүд ерөнхийдөө үе тэнгийн дээрэлхлийн асуудал дээр энэ хууль ямар байр суурьтай, яаж оролцоод байгаа юм бэ гэдэг асуудал яригдаж байна. Тэгэхээр үе тэнгийн дээрэлхэл бол Монгол Улсад хууль тогтоомжуудаар аль хэдийн эрх зүйн орчныг нь бүрдүүлээд, зохицуулаад өгчихсөн байгаа. Гэхдээ юу бид нарт дутуу байгаад байгаа юм бэ гэхээр илрүүлэг. Бид нар хэзээ мэддэг вэ гэхээр фэйсбүүкээр бичлэг тарсны дараа мэддэг. Аль хэдийн хохироод хэдэн жил болчихсон байдаг. Аль эсвэл хэдэн сар өнгөрчихсөн байж байдаг. Түүнээс биш бид нар хэзээ ч сэтгэл зүйчээрээ дамжуулаад, сургуулиар нь дамжуулаад бид нар энийг олж мэдэж амждаггүй. Тэгэхээр энэ хуулиар сэтгэл зүйн зөвлөгөөг цахимаар, биеэр, зайнаас оролц авах бүрэн боломжийг нь олгож байгаа. Дээрээс нь сэтгүүл зүйч нь тухайн сургуульд суралцагчдын сэтгүүл зүйн байдал, сургуулийн орчин нөхцөлийн байдалд ямар тулгамдсан асуудал байгаа вэ гэдэг дээр жил бүр судалгаа явуулж, хариу арга хэмжээг захиралтайгаа нийлж, сум орон нутагтайгаа нийлж авахаар зохицуулагдчихсан байгаа. Тэгэхээр энэ хууль бол илрүүлэгд нь гол анхаарч байгаа хууль шүү. Тэр дээр анхаарах хэрэгтэй байх.

Тэгээд санхүүжилт дээр нэмээд хэлэхэд аюулгүй байдлыг хангахын тулд 3 шатын төлөвлөгөө байгаа. Улсын нэгдсэн төлөвлөгөө, сум орон нутгийн өөрийнх нь онцлогт тохирсон төлөвлөгөө, сургуулийн төлөвлөгөө гээд.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Жадамбаагийн Баясгалангийн урилгаар Чингэлтэй дүүргийн иргэд, Төв аймгийн Аргалант сумын ИТХ-ын төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Алтаншагай гишүүн.

**Н.Алтаншагай:** Нэмж бас нэг санал, тодруулах зүйл байна. Энэ үе тэнгийн дээрэлхлийн талаар соён гэгээрүүлэх болон энэ нийгмийн ухааны хичээлийг гүнзгийрүүлэх, нэмэх, энийг бас тусгаж өгөөч ээ.

2 дугаарт нь боловсролын байгууллагын урсгал засвар гэж маш төвөгтэй асуудал байдаг юм шүү дээ. Японд бол 5 жил болоод л бүрэн урсгал засвар хийгээд явдаг. Монголд бол байхгүй. Боловсролын яаманд нь хүсэлт тавихаар Боловсролын ерөнхий газар билүү нөгөө тендер зохион байгуулдаг, тийшээ ороод 1 дүгээрт алга болчихдог. 2 дугаарт орон нутгийн төсөв дээр энийг нь тавьж болдоггүй, акт тавиулдаг. Тэгээд асуудал үүсдэг шүү дээ. Аудитын шалгалт ороод. Тэгээд энэ чинь өөрөө хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд яг сөргөөр нөлөөлж байгаа юм. Дээврээс нь ус гоожчихсон, хөгцөрчихсөн, ширээ, сандал байхгүй, цөмрөөд орчихсон. 00 үнэртээд байж байдаг ийм сургууль, цэцэрлэг маш олон байна шүү дээ. Жоохон сүйхээтэй цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал өөрсдөө л хөөцөлдөж учрыг нь олдог.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Хүрэлбаатарын Булгантуяа.

**Х.Булгантуяа:** Энэ хүүхдийн эрхийн асуудал бол ер нь нэн чухал болсон. Би харин зүгээр энэ хууль дээр арай жоохон өөр хүлээлттэй байсан юм. Хүүхэд хамгааллын тухай хууль шинэчлэгдэн батлагдаад хэрэгжиж эхлээд удаагүй байгаа. Энэ хууль дээр анх удаа үе тэнгийн дээрэлхлийг хуульчилсан. Сая манай Бум-Очир гишүүн хэд хэдэн чуулган дээр энэ асуудлыг огт хуульчлаагүй, эрх зүйн орчин бүрдээгүй гэж яриад байна лээ. Үе тэнгийн дээрэлхлийг хуульчилсан. Үе тэнгийн дээрэлхэл үүсэх юм бол яах вэ. Хэн, ямар хариуцлага хүлээх вэ гэдгийг нь бид нар хуульчилж өгсөн.

Дээрээс нь нэмээд үл хайхрахыг анх удаа бид нар бас хуульчилсан. Эцэг эх ялангуяа үүргээ ухамсарлаж, үүргээ хүлээхгүй бол яах вэ гэдгийг. Цахим орчин дахь хүүхдийн эрхийг бид нар бас хуульчилсан. Энийг Учрал Ерөнхий сайдыг Цахим, харилцаа холбооны сайд байхад нь бид нар хамтарч хийж байсан. Хэвлэл мэдээлэлд хүүхдийн эрхийг хамгаалахыг бид нар бас хуульчилсан. Одоо 9 сарын 1-нд нөгөө 1 дүгээр ангийн хүүхдүүдээс очоод л нэрийг энд бичээд л, сургуулийг нь бичээд л, ангийг нь бичээд л ингээд л хэвлэлээр гаргаад л тэр хүүхэд тэгж хэлэв гээд өөрснөө өхөөрдөөд яриад суугаад байгаа нь тэр хүүхдийг уг нь эрсдэлд оруулаад байгаа юм. Тэр хүүхэд хулгайлагдах гэх мэтчилэн эрсдэлд оруулах нөхцөл байдал үүсгэдэг юм гээд энийг бид нар бас хуульчилсан. Харамсалтай нь энэ хуулиуд одоо хүртэл хэрэгжиж чадахгүй байгаад байгаа юм.

Дээрээс нь миний зүгээр харж байгаагаар хамгийн чухал нь үе тэнгийн дээрэлхлийг түрүүлээд үүгээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээр судалгаагаар авч чаддаг бол их сайн байна. Тэгэхдээ та бүхэн ер нь ингэж үзсэн үү. Google.mn дээр жишээлбэл, би жишээ авч байна шүү дээ. Бүр аймаар кэйс гэхэд хүн би амиа хорломоор байна гэж бичихэд гадаадын улс орон тэр нь шууд ингээд дохио өгөөд цаашаага сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний цахим систем рүү шууд чиглүүлдэг. Тэр дээр хариулт өгдөг. Та нар тэрийг Google search дээр бичээд аваад үзэхэд түүн дээр нэг UNICEF-ийн билүү пэйж, 2 дахь дээр нь news.mn-ийн нэг статистиктай тоо гарсан гардаг. Тэр уг нь бол шууд энэ чинь тусламж үйлчилгээ рүү чиглүүлэх ёстой байхгүй юу. Гэтэл тийм юм одоо хүртэл байдаггүй.

Дээрээс нь нэмээд цахим орчинд ялангуяа taboo subjects гэж ярьдаг. Хүмүүс ярихаасаа ичмээр байдаг асуудал бол 1 нь нөхөн үржихүйн эрүүл мэнд, нөгөөх нь болохоор сэтгэцийн эрүүл мэндийн асуудал. Тэгэхээр энэ 2-ыг уг нь бол ийм цахим систем байгаад нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар жоохон ичмээр асуултуудаа эцэг эхээсээ асууж чадахгүй, багш нараасаа асууж чадахгүй, найз нараасаа асууж чадахгүй бол тэртээ тэргүй тэр чигээрээ цахим болчихсон энэ хорвоод хүүхдүүд ингээд бичихэд тэр нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудал ч гэсэндээ гардаг байх ёстой. Шархадны СЭМҮТ рүү бол хэзээ хүмүүс ханддаг вэ гэхээр бид нарын монголчуудын ойлголт бол бүр хүндэрвэл л ханддаг гэж боддог. Тэгэхээр үүнийг би уг нь та бүхнийг маш сайн оруулж өгөх юм байна гэж би ойлгосон. Тэр маань жоохон дутуу байна.

2 дугаарт уг нь энэ Хүүхэд хамгааллын шинэ хуулиар хороо болгон, сум болгон хүүхэд хамгааллын нийгмийн ажилтантай болсон. Шинэ хуулиар. Бид нар уг нь бол нэг үеэ бодвол бас төсөв санхүүгийнхээ боломжоор сургууль болгон сэтгэл зүйчтэй болсон, нийгмийн ажилтантай болсон. Харамсалтай нь заримдаа манай нийгмийн

ажилтнуудыг олон юманд ашиглаад, ажлыг нь хийлгэхгүй байгаа боловч уг нь бол энэ эрх зүйн орчин харьцангуй гайгүй болсон.

Тэгээд би ийм хэдэн асуултуудыг та бүгдээс асуух гэсэн юм. Ингэсэн байна. Сургуулийн орчны аюулгүй байдал, энэ бүгдийг ганцхан захирал хариуцахаар тавьчихаж. Захиралд нь төсвийг нь өгөхгүй бол яах вэ. Тэр захирал өөрөө засвараа хийнэ гэсэн үг үү. Та нар үүнийг яаж зохицуулна гэж үзсэн юм бэ. Ингэсэн байгаа юм. Сургуулийн захирал нь сургуулийн барилга байгууламж, биеийн тамирын талбай, энэ газар дээрх аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Ингээд тэр хүнд төсөв байхгүй, хүүхдийн эрх зөрчигдвөл энэ захиралдаа ямар хариуцлага тооцох юм. Төсвийг нь хариуцаж байгаа сайд нь байдаг юм уу. Улсын Их Хурал энэ төсвийг нь батлахгүй байгаа нь үнэн шүү дээ. Ганбат гишүүн түрүүн бас хэлж байна. Ганцхан бараг энэ international school-ээс өөр бусад нь ерөөсөө стандартаа хангадаггүй гээд. Тэгэхээр бүх захирал ажилгүй болно гэсэн үг юм уу. Яана гэсэн үг юм бэ. Энд нэг хариулж өгөөч.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номерын микрофон.

**Б.Оюунжаргал:** Оюунжаргал байна. Орчны аюулгүй байдал дээр бол 3 шатын төлөвлөгөө байгаа.

1-д нь улсын нэгдсэн төлөвлөгөө байгаа.

2-т нь орон нутгийн төлөвлөгөө байгаа.

3-д нь сургуулийн төлөвлөгөө байгаа. Яг үнэн. Төлөвлөгөө байгаа болоод өнгөрөхгүй. Төлөвлөгөөг заавал жил болгон тайлагнана. Улсын төлөвлөгөө бол 4 жилд 1 удаа батлагдана. Орон нутгийн төлөвлөгөө болон сургуулийн төлөвлөгөө нь энэ 4 жилд батлагдсан нэгдсэн төлөвлөгөөг хэрхэн өөрийнхөө хэсэгт хэрэгжүүлж байгаа вэ гэдэг дээрээ тайлагнана. Тэгэхээр энэ тайлагнал нэгдсэн байдлаар улсын нэгдсэн тайлан болоод боловсрол болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудын веб сайтуудаар олон нийтэд тайлагнагдана гэсэн үг. Ингэхээр өнгөрсөн жилийнх хэр хэрэгжиж байна. Энэ жилийнх хэр хэрэгжиж байна. Дараа жил ямар хариу арга хэмжээ авах ёстой вэ гэдэг арга хэмжээнүүд тодорхой болж эхэлнэ. Энэ арга хэмжээнүүд тодорхой болсноороо улсын төсөвт тухайн жилд ямар арга хэмжээг илүү чухалчилж төсөв тогтоогдох вэ гэдэг нь илүү үндэслэл, төсвөөс тэр сургууль урсгал засвар авах тэр боломж нөхцөл нь хариу арга хэмжээнийх нь төлөвлөгөөний гүйцэтгэл, тэр нэгдсэн төлөвлөгөөний гүйцэтгэлийг дагаад бол орж ирэх юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Булгантуяа гишүүн.

**Х.Булгантуяа:** Боловсролын яаман дээр уг нь бол ийм мэдээлэл байдаг. Тийм ээ. Наранбаяр гишүүн ээ. Ямар сургууль ямархуу нөхцөл байдалтай байгаа вэ. Засвар хэрэгтэй юу, үгүй юу гэдэг бүх мэдээлэл байгаа. Түүнийг жил болгон төсөв хэлэлцэж байхад Сангийн яам руу урсгал засвар авмаар байна. Их засвар авмаар байна гэдэг мэдээлэл хүргүүлдэг. Энэ нь ийм төлөвлөгөө байхгүй, хаана ямар сургууль ямар нөхцөл байдал байгаа вэ гэдгээ мэдэхгүй болохоороо энийг хийхгүй байгаад байгаа юм ерөөсөө биш. Гол нь түүнийг нь төсвийг нь тавьж өгдөггүйд л байгаад байгаа юм. Одоо 70 гаруй сургуулиуд 3 ээлж рүү шилжиж байна гэж байна.

Энэ бол юуг харуулж байна вэ гэхээр энэ салбарын хөрөнгө оруулалт шийдэгдэхгүй байна гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр ийм байгаа цагт би зүгээр сургуулийн энэ юуг захирал хариуцна энэ тэр гээд тавихаар хөөрхий энэ захирал л хамгийн сүүлд хариуцлага хүлээгээд дуусах вий дээ.

Энэ дээр нэг таалагдаж байгаа зүйл нь сургуулийн барилгын дэгдэмхий органик бодис хэрэглэх юм бол дор хаяж 28 хоногийн өмнө гүйцэтгэнэ гэдэг бол их зөв. Тэгээд энэ дээр жоохон тодруулаад нэмэлт өгөөч .../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Тодруулга 4 номерын микрофон.

**Д.Нарансүх:** Ажлын хэсгийн гишүүн Нарансүх. Сургууль, цэцэрлэгийн засвар хийхэд будгийн найрлагад байдаг үндсэн уусгагч бодис болох энэ бензол зэрэг цусны хорт хавдар үүсгэдэг хортой бодисуудыг Монгол Улсад бараг бүх сургууль, цэцэрлэг нь засварт хэрэглэж байгаа. Тэгэхээр энэ будгийг бол дор хаяж 28 хоног буюу 4 7 хоногийн өмнө засвар хийж байж энэ будгийн дэгдэмхий шинж чанар нь арилаад, тэр анги танхимд хүүхэд хичээллэхэд эрүүл мэндэд нь эрсдэл учруулахгүй болох учиртай. Тэгэхээр манайд бодит амьдрал дээр засвар хийгээд бараг 4, 5 хоноод л хүүхдээ сургууль, цэцэрлэгт авч байгаа нь нөгөө бага насны хүүхдийн дунд тохиолдоод байгаа цусны хавдар бусад өвчлөлтүүдийн эрсдэлийг бол улам нэмэгдүүлж байгаа. Тэгэхээр энэ асуудлыг зохицуулах ийм заалт судалгаан дээр үндэслээд орсон. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Булгантуяа гишүүн.

**Х.Булгантуяа:** Би энэ дээр нэг ийм санал байгаа юм. Таны хэлж байгаатай бол 100 хувь санал нэгдэж байна. Өмнө нь манай өсвөрийн парламентын хүүхдүүд маань дотор орчны агаарын чанарын асуудлаар НҮБ-ын Хүүхдийн сантай хамтарч ажилласан. Тэгээд энэ дээр бүр үүнийг та бүхэн хууль дээрээ хатуу зааж өгөөч ээ. Эмнэлэг, сургууль, дотуур байр, цэцэрлэгт ашиглагдах барилгын материалын стандартыг маш өндрөөр тавьж өгөөч ээ. Яагаад гэвэл сургууль, цэцэрлэг дотроо хүмүүс ер нь дотор орчинд бараг эсрэгээрээ 90 гаруй хувийг нь бид нар зарцуулдаг. Гадна орчны агаарын чанарыг бид нар ярьдаг мөртөө дотор орчинд бол тийм их бохирдолтой орчинд бид нар суугаад байдаг. Бид нарын хэрэглэж байгаа тэр битгий хэл зарим тавилга, эд хогшил хүртэл энэ формальдегид-ээс авхуулаад бодисуудыг ялгаруулдаг. Гэтэл хүүхдүүддээ бид нар манай тендерийн хуулиар чинь хамгийн хямдханыг нь авдаг. Хамгийн хямдхан юм гэдэг бол угаасаа хамгийн муу байгаад байдаг. Тэр битгий хэл энэ хуулиараа дамжуулаад, сургуулийн форум, түүний материалын стандартыг зааж өгөөч. Хүүхдийн гутлын стандарт.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Пүрэвсүрэнгийн Наранбаяр.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Тэгэхээр энэ сургуулийн орчин, суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хууль. Энэ бол цаг үеэ олсон яг хэлэлцэх ёстой л асуудал гэж ойлгож байгаа. Мөнхсайхан сайдыг бас сайд байхад нь миний бие бас хамтран ажиллаад, нийт 1 дүгээр ангийн хүүхдүүдээс бол зүрх, шүд, сонсгол, ингээд мөн бусад үзлэгүүдийг хийсэн байдаг. Ихээхэн хүчин чармайлт гаргаж, 1 дүгээр ангийн хүүхдүүдээс хийсэн. Эндээс харсан зүйл бол бид санхүүжилтээ яаж шийдэх юм бэ гэдэг асуудал гарч ирж байгаа юм. Тэгэхээр энэ хууль бол би үзэл санаа юмыг нь дэмжээд байгаа юм. Эрүүл мэндийг эрүүл

боловсролтой Монгол хүнийг бий болгоход энэ сургуулийн орчин бол туйлын зөв орчин шаардлагатай.

Гэхдээ би санхүүжилт талаас нь хэдэн зүйл асууя. Ингэж байгаа юм. Хуулийн төслийн 8.4 дээр зөөврийн автомат зүрхний сэдээгчтэй байна гээд. Сургуулиуд дээр. Тэрнийх нь үнийг нь судлаад үзэхээр 1 ширхэг нь дунджаар 8 сая төгрөгийн үнэтэй байгаа юм. Тэгээд зөвхөн төрийн өмчийн сургуулиуддаа энийг байрлуулна гэхээр 700 орчим сургууль байна гэхэд 5,6 тэрбум төгрөг нэмэлтээр шаардлагатай болж байгаа юм.

2 дугаарт нь бол 1-12 дугаар ангийн хүүхдийг бүгдийг нь ийм үзлэг шинжилгээнд оруулна, хамруулна гээд. Тэгэхээр тэрийг ингээд тооцоод үзэхээр энийгээ хувьсах зардалд шингээнэ гэсэн ийм байдлаар орчхож байгаа юм л даа. Гэтэл энэ хувьсах зардал чинь бол үнэхээрийн хүнд нөхцөл байдалтай байгаа шүү дээ. Энийгээ яаж шийдэх юм бэ. Энэ асуудал бас бүрхэг байна. Чухам санхүүгийн тооцоог ажлын хэсэг дээрээ яаж ярилцсан юм. Энийг бас тодруулмаар байна.

Би тэгэхдээ энэ хуулийн төслийг бүхэлд нь эсэргүүцэж байгаа юм биш шүү. Энэ бол хэрэгтэй хууль. Гэхдээ бид энэ санхүүжилтийн механизмыг нь маш сайн харж, эх үүсвэрийг нь маш сайн тавихгүй бол энэ зүгээр нөгөө цаасан дээр тавьчихсан, тунхгийн шинжтэй ийм хууль болж хувирах аюул байна гэж л хэлэх гээд байгаа юм.

Боловсролын яамнаас тухайн үед нь бол саналаа яг оруулсан. Энд бол тусаагүй байна. Аль ч санал нь тусаагүй байна. Яах вэ, тэгээд гишүүн өөрөө санаачлаад ингээд явж байгаа бас болж байна. Гэхдээ бас хэлэлцэх ийм сувгаа бас илүү сайн ажиллуулаач ээ. Ялангуяа энэ захирлуудын зөвлөл гэж байдаг. Захирал багш нартай уулзаж ярилцахгүй бол түрүүн Булгантуяа гишүүний хэлээд байгаа үнэн шүү дээ. Захирлуудад баахан хариуцлага оноочихсон. Багш нарт бас баахан хариуцлага оноочихсон. Тэгэхээрээ багш нар нь энэ хариуцлагыг чинь аваад явах ийм боломж бидэнд байна уу. Энийгээ харахгүй бол энэ чинь нөгөө сургуулийг зүгээр эрүүл мэндийн байгууллага болгож хувиргах ийм хууль болох ийм аюул байна. Би тэгэхдээ энийг эсэргүүцэхгүй гэдгээ хэлээд байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол энэ бол сургууль бол эрүүл Монгол хүнийг торниулах чухал орчин уу. Мөн. Эрүүл хоолоор хооллох ёстой газар мөн үү. Мөн. Гэхдээ энийгээ бид илүү сайн ярилцаж, Эрүүл мэндийн яам, Боловсролын яам 2 их ярилцаж, яг одоо эрх ашиг нь хөндөгдөж байгаа бүхий л байгууллагууд хоорондоо ярилцаж, энийгээ зөвөөр томъёолж оруулж ирэхгүй бол баахан ингээд хооронд нь хувьсах зардлаа ч булаацалдсан, захирлаас нь баахан юм шаардчихсан. Тэгээд тэр нь хэрэгжих боломжгүй. Одоо багшийнхаа ачааллыг хэрхэн бууруулах вэ гэдэг юман дээр бас асуудал үүсэхээр харагдаад байна.

Тэр 19 дүгээр зүйл дээр байгаа стандартын асуудлууд. Сургууль орчинд тавигдах шаардлага энэ маш зүйтэй. Гэхдээ энэ чинь ихэвчлэн стандарт, техникийн зохицуулалтуудаар бол явж байгаа зүйл. Энийг шууд хуульчилж оруулж ирэхийн оронд яг одоо энэ дээрээ бол бид нар энэ техникийн зохицуулалтуудыг ингэж ингэж хийнэ гэсэн зүгээр ийм байдлаар явуулбал яадаг юм бэ. Өөрөөр хэлбэл түрүүн Баасанжаргал гишүүн ч хэлээд байна. Тэр хууль .../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын дэд дарга Жадамбын Бат-Эрдэнийн урилгаар Булган аймгийн Рашаант сумын нийслэл хотод суралцдаг оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Нутгийн оюутнууддаа сурлага хөдөлмөрийн амжилт хүсэж, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Наранбаяр Наранбаяр гишүүнд 1 минут.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Тэгэхээр энэ хууль бичилтийн талаасаа бас анхаарах зүйл байна. Хууль бичилтийнхээ талаас. Энийг та бүхэн энэ саналыг бас авч, энийгээ бас тусгаж ажиллаач ээ. Тэгээд ихэнх гишүүд яриад байна шүү дээ. Түрүүн Алтаншагай гишүүн ч ярьж байна. Бүгд ярьж байна. Энэ үе тэнгийн дээрэлхлийн асуудал хэрвээ орж ирж байгаа бол тэр чинь Хүүхэд хамгааллын тухай хууль дээр байгаа. Гэхдээ энэ орж ирж байгаа бол механизм нь яаж орж ирэх юм. Боловсролын яамны зүгээс бол аюулгүй сүлжээ гэсэн бодлогоо зарласан. Энийг яг энэ хуулийн нэг хэсэг болгож оруулахад бол бэлэн байна. Бид бас энэ яг мэргэжлийн экспертүүдийг нь бас энэ дээр саналаа өгөөд яваасай гэж хүсэж байна. Юу вэ гэхээрээ энэ аюулгүй сүлжээгээр дамжиж энэ үе тэнгийн дээрэлхлийг бүрэн алга болгох, сургуулийн соёлын хүрээнд байхгүй болгох ийм боломж бий. Тэгэхээрээ энэ механизм талаас нь энэ хуулийн төсөлдөө бас тусгах хэрэгтэй байна гэж харж байна. Ингээд хариултаа авъя. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Мөнхсайхан гишүүн.

**Т.Мөнхсайхан:** Наранбаяр сайд маань зарим зүйлүүд дээр маш буруу ойлголттой байна. Боловсролын яамнаас хэд хэдэн удаа, маш олон удаа санал авсан. Болох саналуудыг бүгдийг нь тусгасан. Наранбаяр сайд өөрөө сая ярьж байна. Тэр 1 дүгээр ангийнханд зүрх судасны үзлэг хийсэн. 20 орчим хувь нь зүрхний өвчлөлтэй гарсан шүү дээ. Тэгээд энэ чинь өөрөө юуг илэрхийлээд байна гэхээр эргээд сургуулийн орчинд хүүхэд боловсорч байх хугацаандаа зүрх нь гэнэт зогсох ийм эрсдэл өндөр байна л гэж байгаа юм. Тэгээд бид нар 1 сургууль дээр 8 сая төгрөг орчим төгрөгийн үнэтэй энэ зүрх сэдээгч аппаратыг бид нар тавих ёстой шүү дээ. Тэгээд ганц ийм 8 сая төгрөгийн асуудлаас болоод хүүхэд сургууль дээрээ зүрх нь гэнэт зогсоод нас барах ёстой юу. Энийг бол бид нар шийдэх ёстой.

Энэ урьдчилан сэргийлэх сургуульд суурилсан эрт илрүүлгийн санхүүжилтийг ерөөсөө тэр хувьсах зардлаас авна гэдэг асуудал яриагүй шүү дээ. Өнөөдрийг хүртэл сургуульд суурилсан эрт илрүүлэг оношилгоонууд хийгдэж байгаа. Энэ чинь угаасаа эрүүл мэндийн салбар хийх ёстой, анхан шатынхан хийх ёстой. Энэ хүүхдүүдийн эрүүл мэндэд Эрүүл мэндийн даатгалаас энэ санхүү мөнгийг нь зарцуулах ёстой байхгүй юу. Тэгэхээр энийг Эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлнэ гэдэг нь орчихсон байж байгаа. Зарим нэг зүйлийг хувьсах зардлаас гаргана гээд Боловсролын тухай хуульд чинь орчихсон шүү дээ Наранбаяр сайд аа.

Тэгээд захирлуудад бөөн үүрэг, хариуцлага хүлээлгэх гээд байгаа зүйл биш л дээ. Сургуулийн захирал нь үнэхээр эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах багаа байгуулаад, сургуулийнхаа эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг нь хийгээд, шаардлагатай төсөв мөнгийг нь гаргаад, захиргааны төсвийн ерөнхийлөн захирагч болон орон нутгийн захиргаануудад энэ зүйлүүдийг хүргэчихсэн байх юм бол энэ захирал хийх ёстой ажлаа хийчихсэн байхгүй юу. Энэ хүнд ямар нэгэн хариуцлага тооцохгүй. Энийгээ бид нар хийхгүйгээр өнөөдөр энэ эрсдэл орчноо

тогтоохгүйгээр ямар ийм төсөв мөнгө шаардлагатай байна гэдгээ мэдэгдэхээ байчихсан байхгүй юу. Ямар мэдэгдлээ гээд өгдөг ч биш гээд ингээд бүх зүйл хаягдчихсан байна. Бидний ирээдүй болсон хүүхэд, залуучуудын маань сурах орчин үнэхээр аюултай, эрүүл бус ийм орчин болж хувирсан байна.

Үе тэнгийн дээрэлхэл сургуулийн орчинд, сургуулийн бус орчинд ч их гарч байна. Энэ бусад хуулиуд чинь энэ зохицуулалтыг хийхдээ үе тэнгийн дээрэлхэл гарсных нь дараа ямар арга хэмжээ авах вэ л гэдэг зохицуулалтууд байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар энэ дээр давхардаж дахиж энэ хуулийн зохицуулалтуудыг оруулах шаардлагагүй байхгүй юу. Өнөөдөр яг учир дутагдалтай байгаа үе тэнгийн дээрэлхэл үүсэхээс яаж сэргийлэх ёстой вэ гэсэн л энэ чухал зүйл заалтуудыг оруулчихсан байгаа. Бид нар өнөөдөр илрүүлж чаддаг бол гэж ярьж болохгүй. Бид нар илрүүлж чадах ёстой. Чадахын тулд бүх зүйлийг .../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. 3 гишүүн байна. Даваасамбуугийн Ганмаа. Зүүн индрийн микрофоныг нээе. 2 номер.

**Д.Ганмаа:** Сайн байцгаана уу. Асуулт байх гэж байгаад, үг хэлэх дээр орчхож. Үг болгоё. Тэгэхдээ ер нь бид нар нөгөө Хүний хөгжлийн байнгын хороон дээр ярьсан. Нэлээн хэдэн асуултуудыг асууж тодруулсан. Бас өөрийн хэмжээнд судалсан хууль зүйн асуудлуудыг ч гэсэн Мөнхсайхан гишүүн ажлын хэсэг бүгдэд нь өгсөн байгаа. Хэд хэдэн юм тодруулах хэрэгтэй байх. Энд бас өнөөдөр ярьж байгаа гишүүдтэй нэлээн санал давхцаж байх шиг байна.

1 дүгээрт энэ хууль маань бусад хуулийн 27 зүйл, 109 орчим заалтын 70 гаруй хувьтай хүчин төгөлдөр, одоо үйлчилж байгаа хуультай хэрэгжиж байгаа ч бай, хэрэгжээгүй ч бай ямар ч байсан зүйл заалтын хувьд давхцаж байна гээд 11 хуудас хүснэгт байдлаар хүргүүлсэн. Энэ дээр зүйл, заалтын давхардлыг арилгах, зарим задлалыг дэлгэрүүлэх, шинэчлэх, найруулах, буруу зөрүү эшилсэн шинжлэх ухаанч бусаар хандсан асуудлуудаа янзал гэдгийг нэлээн дэлгэрэнгүйгээр саналаа өгсөн учраас энд давтах хэрэггүй байх гэж бодож байна.

Тэгснээрээ ер нь бид нар энд мөрдөж байгаа хуулиудын хэрэгжилтийг хангахын оронд шинэ хууль нэмээд, шинэ хууль дээрээ шинэ төсөв, шинэ бүтэц, шинэ ачаалал бий болгох нь зөв үү, үгүй юу гэдгийг үр ашгийн хувьд, үр дүнгийн хувьд харьцуулсан ийм судалгаатай нь сайн оруулж ирмээр байна. Жишээлбэл, энэ тогтолцооны уялдаа холбоо зөвхөн захирал ч биш багш нарыг ялангуяа хотын захын сургуулиуд би бараг Улаанбаатар хотын бүх сургуулиуд дээр ямар нэгэн байдлаар биеэрээ очиж байсан. Судалгаа шинжилгээ, эмчилгээ, үзлэг, бүх юмаар. Тэнд хүүхдүүд яг зайлшгүй наад зах нь нөгөө цэвэр ус уух диспенсерээс авхуулаад шаардлагатай юмнууд зөндөө байдаг. Багш, эмнэлгийн ажилчид, захирлуудад тэнд ажиллах орчин их тааруутай байдаг. Сэтгэл зүйчид, багш нарынх нь ажлын ачаалал маш их өндөр байдаг. Өдөрт 50-60 хүүхэд цаг агаарын, юу гэдэг юм агаар солилцох боломжгүй газар ажиллаж хичээллэдэг. Дээрээс нь нэмээд бид нар баахан ажил нэмээд, үүрэг нэмээд, санхүүжилт байхгүй, дэмжих баг байхгүй. Нэмэлт аятайхан

мөнгө төгрөгийг нь олигтой тавихгүйгээр баахан үүрэгжүүлэхээр хэрэгжүүлэхээсээ илүү лай болох вий гэдгээс би үнэн голоосоо бас санаа зовж байгаа.

Тэгээд дээрээс нь нэмэлт тайлан, хяналт, үзлэг, зохион байгуулалтын арга хэмжээг оролцуулах. Энэ дээр зайлшгүй салбарын ачаалал нэмэгдэж байгаа. Энийг бүүр нарийн ширийн тооцож бодоосой гэж бодож байгаа. Эрүүл мэндийн үзлэг хийнэ. Эрүүл мэндийн үзлэг хийхэд багш, хүүхдүүдийн өөрийнх нь зөвшөөрөл. Зөвшөөрлөө яаж бариулах юм. Шинжилгээ авна. Шинжилгээнийхээ бодисуудыг хаана, яаж хадгалах вэ. Яаж энийгээ эх эцэгт ойлгуулах вэ. Яаж энийгээ дараа нь мэдээллээ нээлттэй бус, хаалттай, хамгаалалттай, аюулгүй хувь хүний мэдээллийг зөв орчноор бид нар дамжуулах уу. Тэрийгээ юунд хэрэглэх вэ гээд бас нэлээн олон асуудлуудыг энд ярих нь зайлшгүй шаардлагатай гэж бодож байна. Тэгээд ер нь бид нар эрүүл мэнд буюу эрүүл мэндийн салбар, нийгмийн эрүүл мэнд гэдэг чинь 1 том малгайтай 1 том хууль, 1 том чиглэл бодлого урт удаан, дунд хугацааны бодлого гэж байх ёстой. Гэтэл бид нар тус тусад нь баахан нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр гээд баахан мөнгө энд тэнд суулгачихдаг шүү дээ. Эрүүл тийм юм, эрүүл ийм юм, эрүүл ийм юм. Ороод л уншихаар зэрэг баахан хөтөлбөрүүд. Тэгсэн мөртөө яг үр дүн, үр ашиг яасан юм бэ. Нэгдмэл бодлого хаана явж байгаа юм бэ. Энийг хэрэгжүүлснээр өвчлөл яаж бууруулсан юм. Нас баралт, хүндрэлээ багасгасан гэсэн тоо их цөөн байдаг. Энэ дээр ч гэсэн зайлшгүй хармаар санагдаж байгаа.

Тэгээд сургуулийн орчны, цэцэрлэгийн орчны, коллежийн орчны, их сургуулийн орчны, үйлдвэрийн, уурхайн орчны эрүүл мэнд гээд тус тусдаа хуулиа хийгээд явах юм уу. Энийг яаж уялдаатай ажиллах юм. Эдгээр асуудал дээр нарийвчлан харж хэлсэн, ярьсан засваруудыг зайлшгүй оруулаасай гэж хүсэж байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Цэндийн Баатархүү. Одсүрэнгийн Номинчимэг.

**О.Номинчимэг:** Энэ хуулийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байна. Мэдээж гишүүдийн хэлж байгаа нарийвчилсан асуудлуудыг анхаараад, Улсын Их Хурал дээрх хэлэлцүүлгийн шатад сайжруулах тал дээр бол ажиллаад явах байх гэж бодож байна. Ер нь бол энэ хуулийн үзэл баримтлалд байгаа эрүүл Монгол хүнийг бид нар яаж бүтээх вэ гэдэг асуудал байгаад байгаа. Тэгээд эрүүл Монгол хүн энэ улсыг авч явахаас, суурь өвчлөлтэй, багаасаа шим тэжээлийн дутагдалтай явж ирсэн хүмүүс эрч хүчтэй ажиллаж чадахгүй. Монгол Улсын ирээдүйг сайхнаар бас харж чадахгүй. Сургуулийн насны хүүхдүүдийн ер нь 90 хувь нь Д витамин дутагдалтай байна гэсэн судалгаа гарсан. Энэ бол 10 хүүхэд тутмын 9 нь гэсэн үг. Шүд цоорох өвчний тархалтаар Монгол Улсын хүүхдүүд дэлхийн дунджаас 2 дахин их байна. Сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ нь байх ёстой хэмжээнээсээ 3 дахин их байна гэдэг ийм дүн шинжилгээнүүд гараад байгаа. Энэ бол ерөөсөө л нийгмийн эрүүл мэнд. Энэ асуудал дээр бодлогын алдагдал байна гэснийг харуулж байна. Бага насны хүүхдүүдийн 42,2 хувь нь чихэр, шоколад, шарсан төмс гэх мэт эрүүл бус хүнсийг байнга хэрэглэж байна. Сургуулийн кафед ч гэсэн ийм зүйл л их байна. 36,7 хувь нь чихэрлэг ундаа хэрэглэж байна гэсэн ийм судалгаа байгаа. Тэгээд ерөөсөө бид нар энд ойлголт дадлага, юу гэдэг юм соён гэгээрүүлэх ажил, бодлого хаягдсаны жишээ энэ тоогоор харагдаж байна гэж харж байгаа. Ийм амьдралын хэв маягтай болсон Монгол Улсын ирээдүй болсон хүүхдүүдийг сургуулийн орчинд нь эрүүл хоол хүнсээр, аюулгүй хоол хүнсээр хангах, шим тэжээлийн боловсролыг нь олгох энэ зохист дадалд нь сургах асуудлыг бол бид одоогоос маш сайн

анхаарахгүй бол улаан дохио гарсан байна гэж харж байгаа. Олон зүйлийг бол мэдээж өргөн хүрээнд энийг хийх шаардлага байгаа гэж харж байгаа.

Өчигдөрхөн Өргөдлийн байнгын хороон дээр одоо ЕБС-ийн үдийн хоолны шим тэжээлийн асуудлыг бид хөндөж, хуулийн хэрэгжилтийг хөндөж ярилцсан. Эрүүл мэндийн яамны өгсөн мэдээллээр бол хот суурин газрын хүүхдүүдэд таргалалт, жингийн нэмэгдэл маш их байна. Нийтдээ 30-аад хувь нь жингийн нэмэгдэлтэй, таргалалттай байна. Алслагдмал сум, дүүргүүдэд бол харин хүүхдүүдийн хувьд шим тэжээлийн дутагдалд орсон дундаж өндрөөсөө даруй 2-3см бага байна гэсэн ийм судалгаануудыг гаргасан байна.

Хөдөө, орон нутагт ч гэсэн дотуур байранд 1 хүүхдийн хоолны мөнгийг 6300 төгрөгөөр одоо тогтоож байна. Энэ мөнгө бол мах 9 мянга, 10 мянга байсан үеийн тооцоолол. Одоо энэ махны үнэ 3 дахин өсчхөөд байхад энэ дотуур байранд амьдарч байгаа, орон нутагт амьдарч байгаа хүүхдүүдийн хувьд хооллож байгаа хоолноосоо өдрийн шим тэжээлээ хангалттай авч чадахгүй байгаа гэдэг нь ойлгомжтой зүйл болоод байна. Энийг Боловсролын яамны судалгаагаар даруй 9-10 мянга болгох шаардлагатай. Энд нийтдээ 32 тэрбум төгрөг л шаардлагатай байна гэдгийг хэлж байгаа.

Тэгээд бага ангийн хүүхдүүдээс илүү бас дунд, ахлах ангийн хүүхдүүдийн хувьд шим тэжээлээ авч чадахгүй байна гэсэн судалгаа ч гарсан. Энд бол дахиад 200-аад тэрбум төгрөг шаардлагатай юм байна. Тэгээд энэ 260-аад тэрбум төгрөгийг шийдээд өгөхөд Монгол Улсын төсөв дампуурчих гээд байгаа юм бол байхгүй гэж харж байгаа. Монгол Улсын төсөв бол чамлахааргүй. Мэдээж бид нарын хийх ёстой, хямгадах ёстой, зардлаа танах ёстой, хөрөнгө оруулалтаа нэмэх ёстой зөндөө асуудлууд байгаа. Гэхдээ мөнгийг хүүхдүүдээсээ ялангуяа энэ шим тэжээлийг сайжруулах асуудалд зарцуулахгүй байх нь ирээдүйгээ хорлож байгаа үйл явдал гэж харж байна.

Өнөөдөр ч гэсэн энэ хуультай холбоотой төсвийн асуудлуудыг хөндөж байгаа. Гэхдээ бид нар төсөв дээрээ энэ ирээдүй хойч үеэ халбага хоол гэж бодолгүйгээр хөрөнгө оруулах нь дараагийн дараагийн эрүүл Монгол хүүхдүүдээ бий болгоход хамгийн том хөрөнгө оруулалт гэж харж байгаа. Энэ асуудал бол зөвхөн мэдээж төсвийн асуудал биш ээ. Дараа нь хоол шим тэжээлийг яаж зөв зохистойгоор өгөх вэ, боловсролыг нь яаж олох вэ, эрүүл, аюулгүй орчныг нь яаж хандах вэ гэдэг асуудалд цаашид бид бас .../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргалын урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын Монгени сургуулийн 10<sup>в</sup> ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хууль хэлэлцэж байхад та бүхэн сурагчид маань орж ирлээ. Бас та бүхэнд сонирхолтой байсан болов уу гэж бодож байна. Ингээд та бүхэндээ сурлагын их өндөр амжилт хүсэн ерөөе.

Гишүүд үг хэлж дууслаа. Одоо Байнгын хорооны саналаар Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалт.

1.Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал. Хураалтад 114 гишүүнээс 73 гишүүн оролцож 64 хувиар санал дэмжигдлээ.

2.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Санал хураалтад 114 гишүүнээс 72 гишүүн оролцож, 62,2 хувиар санал дэмжигдлээ.

Ганбаатар гишүүнийг тэмдэглэе. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 114 гишүүн оролцсоноос 76 гишүүн дэмжиж, 66,7 хувиар санал дэмжигдлээ.

4.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт санал. Хураалтад 114 гишүүнээс 76 гишүүн оролцон дэмжиж, 66,7 хувиар санал дэмжигдлээ.

Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих санал хураалтад гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

16.05 цаг.

2 дахь асуудал руу оръё.

### **Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох асуудал**

Монгол Ардын намаас Монгол Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлсэн тухай Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Жигжидийн Батжаргал танилцуулна. Батжаргал гишүүнийг индэрт урьж байна.

**Ж.Батжаргал:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 11 дүгээр зүйлийн 11.1, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн 2026 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хуралдааны шийдвэрийн дагуу Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогтыг Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлж байна.

Сандагийн Бямбацогт 1974 онд Ховд аймагт төрсөн. Эхнэр 3 хүүхдийн хамт амьдардаг. Тэрээр 1999 онд СЭЗДС, 2005 онд Нидерланд Улсын Маастрихтын их

сургууль, 2014 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг тус тус төгссөн. Эдийн засагч, эрх зүйч мэргэжилтэй. Эдийн засаг, бизнесийн удирдлагын болон Хууль зүйн ухааны магистр зэрэгтэй.

Сандагийн Бямбацогт 2000-2008 онд Нью прогресс группийн захирал, ТУЗ-ийн дарга, 2008 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2012-2013 онд Монгол Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга, 2013-2016 онд Монгол Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга, 2016-2017 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд, 2019-2020 онд Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, 2020-2022 онд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга, 2022-2024 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд, 2024-2025 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд, 2025 оноос Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар тус тус ажилласан.

Бямбацогт иргэд, сонгогчдын итгэлийг хүлээж Улсын Их Хурлын гишүүнээр тасралтгүй 5 удаа сонгогдон ажиллаж байна. 50 гаруй хуулийн төслийг санаачилж, ажлын хэсгүүдийг ахлан ажилласан бөгөөд 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эх баригчдын нэг, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого тодорхойлогч Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай анхдагч хуулийн төслийг санаачлагч, эрх зүйн олон шинэтгэлийг амжилттай хэрэгжүүлсэн мэргэшсэн парламентч юм.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогтыг хууль тогтоох байгууллагад ажилласан байдал, боловсрол, мэдлэг, туршлагыг харгалзан Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлж байна. Холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Батжаргал гишүүнд баярлалаа. Одоо Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох санал хураалт явуулна. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл.

**О.Цогтгэрэл:** Гишүүддээ үдээс хойшийн мэндийг хүргэе. Бас энэ хаврын чуулган эхлэхээс бас эхэлсэн Ардчилсан намын бүлгээс тавьж байгаа зарчмын асуудал, тэрний үргэлжлэл болсон бас ингээд үйл явц өрнөж байна. Яг энэ Улсын Их Хурлын даргатай холбоотой. Тэгэхээр гол учир шалтгаан нь сүүлийн 2 жилийн хугацаанд хамгийн тогтвортой ажиллах ёстой парламентын спикер үндсэндээ 3 дахь хүнийхээ нэр дээр сонголт Улсын Их Хурал хэлэлцэж байна л даа. Тэгэхээр үүний цаана Ардчилсан намын бүлгээс тавьж байгаа яг үндсэн шаардлага, шаардлагын хүрээнд бид нар бас хуулийн төсөл өргөн барьчихсан байгаа. Хуулийн төслийн үзэл санаанд зөвхөн ганц заалт биш хэд хэдэн чухал зүйл заалтууд бас бий. Тэгэхээр энэ хүрээнд бид нарын хувьд бас ярилцаж, хэлэлцэх шаардлагатай гэдэг ийм байр суурийг Ардчилсан намын бүлгээс бас илэрхийлж байна. 1 дүгээрт.

2 дугаарт нь одоо яг сая танилцуулга хийгдээд, шууд санал хураалт гэж байна. Тэгэхээр энэ дахиад л Улсын Их Хурлын тухай хуульд маш учир дутагдалтай, 5 намын 126 гишүүнтэй парламентын даргыг сонгох гэж байж ямар ч

хэлэлцүүлэггүйгээр, асуулт хариултгүйгээр явахаар дэглэчихсэн. Энэ гэхэд өөрөө бид нар асууж ярьж, хэлж захиж, ойлголцож байж энэ асуудал. Тэгэхээр яг энэ Улсын Их Хурлын даргыг сонгохтой холбоотой, томилохтой холбоотой процесс дэг дээр үнэхээр олон олон ийм учир дутагдалтай асуудлууд бас энд бий. Тэгэхээр Ардчилсан намын бүлгээс яг энэ асуудал дээр яаралтай горимоор хууль, эрх зүйн дэгийн ямар боломж байна. Тэмүүжин гишүүний хуулийг яаралтай горимоор батлах шаардлагатай гэж бид нар бас байр суурьтай байгаа. Тэгэхээр энийг бид нар завсарлага аваад, энэ тухайгаа бас ярилцаж, байр сууриа нэгтгэх шаардлагатай байна. Ийм учраас Ардчилсан намын бүлэгт хуралдаан даргалагч ажлын 3 хоногийн завсарлага өгөөч ээ. 1 дүгээрт.

2 дугаарт нь бас заавал нэг зүйлийг тодотгож хэлэх ёстой нь Бямбацогт гишүүн Улсын Их Хурлын даргад нэр дэвшиж байгаа юм байна. Бямбацогт гишүүнтэй холбоотой ямарваа нэг субъектив, хувь хүнтэй холбоотой асуудал энд ямарваа нэгэн зүйл байхгүй байгаа. Парламентад хамгийн олон сонгогдсон цөөхөн гишүүдийн 1, бас энэ ажлыг хийгээд явчих бүрэн дүүрэн боломжтой гэж олон гишүүн бас үзэж байгаа байх. Тэгэхдээ энэ нь өөрөө энэ асуудал энэ чигээрээ явбал бид нар зарчим биш, хувь хүнд тааруулж асуудал ярьсан, шаардлага тавьсан, улс төрийн шаардлага тавьсан ийм нөхцөл байдалд орно. Тэгэхээр зарчмыг зарчмаараа, үүсэл гарлын асуудлыг, тэр үндсэн шалтгааныг нь хэдүүлээ засаад бас Монголын парламенттай олон улсын дэг жаягт нь олон улсын тэр парламентын ардчиллын төлөө бас онол номынх нь дагуу хэдүүлээ хийж ажиллая гэдэг ийм зарчмын хүсэлт шаардлага, ярилцах ёстой зүйлс байгаа юм. Ингээд таныг завсарлага өгөхийг хүсэж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Та бүхэн маань Улсын Их Хурлын үйл ажиллагаа бас тасалдаад байна гэсэн ийм саналыг тавьсан байх. 3 хоног гэдэг маань их байна даа. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн даргын гаргасан саналын дагуу ажлын 1 хоногийн завсарлага өглөө. 1 хоногийн завсарлага өглөө.

16.13 цаг.

Дараагийн асуудалдаа орёе.

**“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр” соёрхон батлах тухай хуулийн төсөл.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал танилцуулна. Учрал сайдыг индэрт урьж байна.

Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар Эрдэнэбатын урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын Гэгээ сургуулийн 9, 10 дугаар ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багш, сурагчдадаа сурлагын өндөр амжилт хүсэн ерөөе.

Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сүрэнжавын Лүндэг танилцуулна.

**С.Лүндэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасныг үндэслэн 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Жангабыл ОХУ, БНСУ-тай хөдөлмөр, нийгэм хамгааллын хүрээнд байгуулсан гэрээ хэлэлцээрийг шинэчлэх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганбат гадаад улсад хөдөлмөр эрхэлж буй иргэдийн бодит судалгаа, мэдээлэл, нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Наранбаяр манай улсын иргэд олноор ажиллаж амьдарч байгаа Япон Улстай гэрээ хэлэлцээр байгуулах эсэх талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн богино хугацаагаар гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн эрх ашгийг хэрхэн хамгаалах талаар, Монгол улсад ажиллаж амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, ажилгүйдлийн түвшнийг бууруулан ажиллах хүчний асуудалд дүн шинжилгээ хийж байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ганбат гадаад улсад ажиллаж амьдарч буй иргэдийн гэр бүл, хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах талаар, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн гадаад улс орнуудад ажиллах хүчээ алдахгүй байхад бодлогын түвшинд анхаарах шаардлагатай талаар үг хэлсэн болно.

“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Туваан гишүүнээр тасаллаа. Ганбат гишүүнээр тасаллаа. Бум-Очир гишүүн.

**Д.Бум-Очир:** Юуны өмнө энэ хэлэлцээрийг дэмжиж байгаагаа илэрхийлмээр байна. Тэгээд өмнө нь бол яг Казахстантай ийм хэлэлцээр хийсэн. Их Хурлын чуулганаар мөн яригдсан. Тэр үед би бас асууж байсан юм. Америкт байгаа Монгол иргэд яг энэ хэлэлцээрийн асуудлаар маш их асууж сурагладаг. Тэр үед би бас яг энэ Америктай хийж байгаа хэлэлцээр ямар шатанд явж байгаа вэ гэдгийг тодруулж асууж байсан. Тэр үеийн үйл явц, процесс хэр урагшилсан бэ. Энэ тал дээр мэдээлэл авмаар байх юм. Яагаад гэхээр Америкт бараг 40 гаруй мянган Монголчууд байгаа. Энэ хэлэлцээрийн үр дүнд тэнд байгаа 1 Монгол хүний аж амьдрал, асуудал тодорхой хэмжээгээр шийдэгдэж байдаг ийм чухал ач холбогдолтой юм. Тэгэхээр энэ Америктай хийж байгаа хэлэлцээр маань ямаршуу

шатад явж байгаа бол. Сүүлд ярьж байсан тэр шатаас ямар зүйл ахисан бол гэдэг дээр хариулт авмаар байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэн хариулах вэ. 4 дүгээр микрофон.

**Л.Мөнхзул:** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Мөнхзул. Гишүүний асуултад хариулъя. АНУ-д 45,6 мянган иргэн ажиллаж амьдарч байна гэсэн ийм тоон мэдээ байгаа. Үүнд бол хууль бусаар бас оршин сууж байгаа иргэдийг оролцуулаагүй. АНУ-тай хийсэн хэлэлцээрийн асуудлаар өнгөрсөн 2025 оны 10 дугаар сард Монгол Улсаас АНУ-д суугаа ЭСЯ дээр бас манай яамны холбогдох төлөөлөл очиж ажилласан байгаа. Тэгээд ЭСЯ-аас бол бид нар онлайн-аар уулзалт хийж байгаа. Ингээд Америкийн талтай бол ЭСЯ-аар дамжуулан Гадаад хэргийн яамаар дамжуулан ажиллаж байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Цэвэгдоржийн Туваан гишүүн.

**Ц.Туваан:** Энэ 2 улсын хоорондын хэлэлцээрийг маш хурдтай батлаад өгчихсөн нь зөв гэдэг саналтай байна. Тэгээд ажлын хэсгээс тодорхой нэг асуулт байгаа.

Монгол Улс нийтдээ яг энэ төрлийн хэлэлцээрийг дэлхийн нийт хэдэн улстай хийсэн байгаа вэ. 1 дүгээрт.

Цаана нь хийгдэхээр хүлээгдэж байгаа ямар улсын хэлэлцээрүүд байгаа вэ гэдэг 2 асуулт.

Дээрээс нь яг энэ төрлийн хэлэлцээр хийгдсэн хамгийн олон Монгол Улсын иргэн амьдарч байгаа 5 улсыг, тэнд амьдарч байгаа иргэдийнх нь тоотой нь тодруулаад хэлээд өгөөч гэсэн ийм асуулт байна.

Дээрээс нь энэ улс хоорондын хэлэлцээрүүдийг бид нар бас их нухацтай хандаж, хариуцлагатай хандаж хийж баймаар байгаа юм гэдгийг хэлье. Энэ дээр өмнө нь бид нар бас 2 хөрштэйгөө хийсэн хэлэлцээр, дээрээс нь ОХУ-тай хийх газрын тосны бүтээгдэхүүн, онгоцны түлшний хэлэлцээр гээд бид бүхэн тухайн үедээ бас улс төржөөд энэ асуудал дээр нэлээн хайнга хандаад, баталж өгөхгүй буцаагаад явуулж байсан. Тэрнээс хойш цаг хугацаа маш хурдан өнгөрч байна. Тэгээд 1 жилийн хугацаа дотор энэ хэлэлцээр одоо л дөнгөж орж ирэх гээд явж байх шиг байна.

Тэгэхээр үүнээс болж энэ нефть, бүтээгдэхүүний хангамж өнгөрсөн хугацаанд ямар их асуудал болов. Өнгөрсөн намар, өвөл хангамж дээр асуудал боллоо. ОХУ-тай манай улсын төрийн дээд өндөрлөгүүд, дээрээс нь харьяа яамдынх нь сайд нар энэ тэр бараг л очиж гуйх нь холгүй л нэлээн олон юм боллоо шүү дээ. Тэгэхээр иймэрхүү асуудлуудаа бас нэлээн хэдүүлээ Улсын Их Хурал бас хариуцлагатайгаар хийчхэж баймаар байгаа юм. Улс төржилтөө бага хийчихгүй бол үр дагавар нь их гараад байгаа юм. Үүний хамгийн тод жишээ бол энэ газрын тосны бүтээгдэхүүн дээр гарч байгаа шүү.

Одоо тэгээд дахиад бид нар Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулаад энэ онцгой албан татвараа тэглэх гээд, тэгээд хангамжтай холбоотой, үнэтэй

холбоотой маш олон эрсдэлтэй асуудал руу орчихсон байна шүү гэдгийг бас энэ ташрамд хэлье. Тэгээд асуултдаа хариултаа авъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номерын микрофон.

Онцгой байдлын ерөнхий газрын төв орон нутгийн онцгой байдлын газрын орлогч дарга нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

**В.Рэнцэнханд:** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга Рэнцэнханд. Туваан гишүүний асуултад хариулъя.

Монгол Улс одоогийн байдлаар бол 7 улстай нийгмийн хамгааллын хэлэлцээртэй байгаа. Тухайлбал ОХУ-тай 1981 онд хийсэн хэлэлцээртэй байна. Тэгээд ОХУ-д бол Монгол Улсын 3466 иргэн байна гэсэн мэдээлэлтэй байна. БНСУ-тай бас хэлэлцээртэй байгаа. Энэ хэлэлцээр бол 2007 оноос эхлээд хэрэгжиж эхэлсэн. БНСУ-д бол 55900 Монгол иргэн байна гэсэн мэдээлэлтэй байна. Унгар улстай бас хэлэлцээр хийсэн байгаа. Унгар улсын хэлэлцээр бол 2012 оноос эхлээд хэрэгжиж эхэлсэн хэлэлцээр байгаа. Унгар улсад бол Монгол Улсын улсын 5744 иргэн бол байна. БНПУ, БНТУ, БНЧУ-уудтай бол хэлэлцээрүүд бас хийгдсэн байгаа. Хамгийн сүүлд БНКАУ-ын хэлэлцээр бол 2026 оны 4 сарын 1-ний өдөр буюу өчигдрөөс эхлээд хэрэгжиж эхэлсэн байгаа.

Энэ хэлэлцээр хийгдсэн улсуудад бол Монгол Улсын нийтдээ 92147 иргэн бол ажиллаж байна. Тэгэхээр зэрэг энэ хүмүүс бол нийт гадаадад байгаа иргэдийн бол 35 орчим хувь нь байна гэсэн судалгаа байна.

Цаашдаа бол Бүгд Найрамдах Австрали Улстай бид нар хэлэлцээ хийгдээд явж байна. Австраличууд өнгөрсөн 11 сард бол Монгол Улсад хийгээд хэлэлцээ бол хийгдээд явж байгаа. Мөн ХБНГУ-аас бол 2027 оноос эхлээд хэлэлцээгээ хийж эхэлье гэсэн ийм мэдээлэлтэй байгаа. АНУ-тай бас хэлэлцээнийхээ үйл ажиллагааг ингээд эхлүүлээд явж байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дашдондогийн Ганбат гишүүн.

**Д.Ганбат:** Энэ гэрээ хэлэлцээрийг дэмжиж байна. Юу билээ нөгөө дэд сайд нар маань хаачаад байна. Би харин энэ дэд сайдуудыг одоо бол их олзуурхаад байгаа шүү. Яг хэрэгтэй байдаг юм байна. Энэ бас Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагаа хэвийн явагдахад. Тэгсэн мөртөө энэ дэд сайдууд нь харагдахгүй юм. Хэдэн баярын мишээл тодорсон, насныхаа хоолтой залгачихсан юм шиг л хэдэн залуучууд гүйлдээд байсан. Одоо эд нар эндээ байж баймаар байна шүү.

Ер нь манай Аубакир сайд болж байна, болж байна. Он дуусахад Казахстантайгаа гэрээ хэлэлцээр байгуулчихсан. Сайн байна. Ер нь гадаадад 300-аад мянган хүн ажиллаж байгаа гэж байгаа. Энэ хүмүүсийн хэдэн хувь нь даатгал төлж байна вэ гаднын улсуудад. 7, 8 улстай гэрээ хэлэлцээр байгуулчихсан байна. Тэгээд энэ хүмүүс маань ямаршуухан ажил эрхлээд байна вэ. Гаднын улсуудад яг тэр дэлхийн иргэд шиг ганц нэгхэн хүн л гайгүй компанид л ажиллаад байх шиг байх юм. Энэ улс орныг хүн тогтохын аргагүй болгочихсон. Тэгээд л бүгд л залуучууд зугтаж гараад байна л даа. Явж явж хэдэн Улсын Их Хурлын гишүүд л үлдэх байх

даа. Тэгээд ганц нэг сайдууд л үлдэх юм уу, яах юм. Ийм л болчих гээд байна. Тэгэхээр энэ гэрээ хэлэлцээр бол маш их ач холбогдолтой. Сайн хийх хэрэгтэй.

Тэгээд яг дэлхийн түвшний тэр ажил төрлийг хийгээд байгаа ийм хэдэн хүн байна вэ. Тэр нийгмийн даатгалынхаа үр өгөөжийг яаж хүртэх юм бэ. Эрүүл мэндийнхээ даатгалыг. Гаднын улс орнуудын энэ ардчилсан хөгжилтэй улс орнуудын иргэд бол тэр тэтгэвэр, тэтгэмжээ аваад, аялал зугаалгаар яваад, эмчлүүлээд ингээд хүрэлцээтэй мөнгө байдаг л даа. Энэ ямар байдалтай байгаа юм гэдгийг нь л би асууя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хариулт. Ажлын хэсгийн 4.

**Б.Батжаргал:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын ерөнхий газар Батжаргал. Одоогийн байдлаар нийтдээ 7 улстай хэлэлцээртэй байгаа. 7 улстай хэлэлцээр байгаагийн үр дүнд гадаадад байгаа монголчуудын нийтдээ 35-38 орчим хувь нь бол нийгмийн даатгалын тогтолцоонд хамрагдсантай адилхан ийм нөлөөтэй үйлчилгээ үзүүлэх ийм хэлэлцээрүүд хэрэгжиж байна. Одоогийн Монгол Улсын нийгмийн даатгалын тухай хуулиар бол нийгмийн даатгалд гадаадад байгаа монголчууд даатгуулах боломж нь бол нээлттэй. Заавал биечлэн ирэх шаардлагагүй болсон. Цахимаар даатгуулах бүх сувгийг нь бол нээгээд өгчихсөн байгаа. Нийт хамгийн сүүлийн тоогоор бол 4000-5000 орчим даатгуулагч гадаад улсаас Монгол улсдаа даатгуулаад явж байна гэсэн тоо баримт байна.

Дараагийн удаад Австрали, бусад улсуудын хэлэлцээр ороод ирэх тусам гадаадад байгаа монголчуудын даатгалд хамрагдах хувь бол 50-60 хувь болох ийм боломж бас бүрдэж байна гэж харж байгаа. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ганбат гишүүн тодруулъя.

**Д.Ганбат:** Энэ гэрээ хэлэлцээр хийгээд хэчнээн хэмжээний мөнгө шилжиж орж ирж байна. Тэр зохих хэмжээнийхээ тэр орж ирсэн мөнгөнийхөө үр өгөөжийг хүртэж чадаж байгаа юу, үгүй юу л гэж асуугаад байна л даа. Энэ талаар хариулт сонсчихмоор байх юм.

Тэгээд энэ олон гэрээ хэлэлцээрүүд явж байгаа. Гадна дотнын. Тэгээд чоно борооноор, аливаа юм үймээнээр гэдэг шиг энэ Засгийн газар бүрэн бүрдэж амжаагүй үед тэр Чингис хаан онгоцны буудлын гэрээ хэлэлцээр, бензин тосыг батална энэ тэр гээд яваад байх юм. Тийм эх орноосоо урвасан үйлдэл гаргаж болохгүй шүү. Тэр арбитрын шүүх нь бол хачин юм байна лээ шүү дээ. Энэ юмыг дараа бас нэлээн анхаарч үзэж байж хийх ёстой ийм бас гэрээ хэлэлцээрүүд байгаа шүү.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хэлэв үү. Ажлын хэсэг 4 номер.

**Б.Батжаргал:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын ерөнхий газар Батжаргал. Одоогийн байдлаар яг хэлэлцээрийн үр дүнд тэтгэврээ тогтоолгоод, гадаад улсаас тэтгэврээ давхар авч байгаа хүний тоо бол 308 байна. Энд бол Польш улс дээр 4, Унгар улс дээр 58, Чех улс дээр 6, Солонгос дээр 7, ОХУ дээр 233 гэсэн тоотой байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье. Болж байна уу. Болсон уу. Нийт гишүүдийн олонхоор батална. 64 дээр нэмэх нь 1.

“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Нийт 114 гишүүнээс 79 гишүүн дэмжиж, 69.3 хувиар санал дэмжигдлээ. Пүрэвдорж гишүүнийг санал өгснөөр авъя.

Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх дэмжсэн тул хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийг эцэслэн баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын гишүүд ажлын хэсэгт талархлаа илэрхийлье.

16.31 цаг.

Дараагийн асуудалд оръё.

### **“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал танилцуулна.

**Н.Учрал:** Эрхэм Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ, Улс орны эдийн засаг, уул уурхай, үйлдвэрлэлийн өсөлттэй холбоотойгоор манай улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ жил бүр өсөн нэмэгдэж, 2025 онд импортын хэмжээ 2,9 сая тонн болж өмнөх оноос 0,1 сая тонноор өссөн байна. Цаашид 2026 онд 3 сая тонн, 2027 онд 3,1 сая тоннд хүрэх төлөвтэй байна.

Өнөөдрийн байдлаар манай улс шатахууны хэрэглээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд нийт импортын 98 орчим хувийг ОХУ, үлдсэн хувийг БНХАУ эзэлж байна. Манай гол ханган нийлүүлэгч ОХУ-ын Роснефть компанийн 4 дүгээр сарын хил үнэ өмнөх сараас тонн тутамдаа энгийн дизель түлш Евро 5 АИ 92 авто бензинээр нэмэгдэж 1206 доллар, АИ 95 авто бензин 441 доллароор нэмэгдэж, 1176 доллар, АИ 98 авто бензин 441 доллароор нэмэгдэж, 1226 болж төрлөөс хамаарч 441-648 доллароор өссөн байна.

Үүнтэй холбоотойгоор дотоодын зах зээл дэх энгийн АИ 92 авто бензинээс бусад төрлийн шатахууны борлуулалтын үнэ энгийн дизель түлш 2200 төгрөгөөр нэмэгдэж, 5200 төгрөг, Евро 5 дизель түлш 1300 төгрөгөөр нэмэгдэж, 5300 төгрөг, Евро 5 АИ 92 авто бензин 1100 төгрөгөөр нэмэгдэж, 4200 төгрөг, АИ 95 авто бензин 500 төгрөгөөр нэмэгдэж, 4100 төгрөг болж тус тус нэмэгдэх нөхцөл байдал үүсээд байна.

Цаашид Ойрх Дорнодын мөргөлдөөн энэ хэвээр үргэлжилж улам хурцдаж брэнд төрлийн газрын тосны үнэ баррель нь 130 ам.долларт хүрсэн нөхцөлд манай улсад нийлүүлэх дизель түлшний хил үнэ тонн тутамд 1750 ам.доллар, жижиглэнгийн үнэ литр тутамд 3296 төгрөгөөр нэмэгдэх, тосны үнэ 150 ам.долларт хүрсэн нөхцөлд манай улсад нийлүүлэх дизель түлшний хил үнэ тонн тутамд 2019

ам.доллар болж, жижиглэнгийн үнэ литр тутамд 4235 төгрөгөөр нэмэгдэх, тосны үнэ 200 ам.долларт хүрсэн нөхцөлд манай улсад нийлүүлэх дизель түлшний хил үнэ тонн тутамд 2693 ам.доллар болж, жижиглэнгийн үнэ литр тутамд 6587 төгрөгөөр нэмэгдэж, 1 литр дизель түлшний үнэ 9700 төгрөг болох эрсдэлтэй байна.

Манай улс ОХУ-ын гол үйлдвэрлэгч нийлүүлэгч Роснефть компанитай хэлцэл хийсний үр дүнд өргөн хэрэглээний бүтээгдэхүүн болох АИ 92 шатахууны хил үнийг 2022 оны 5 дугаар сараас хойш 705 ам.доллараар тогтворжуулан жижиглэн борлуулалтын үнэ гадаад зах зээлээс хамааралтай үнийн өөрчлөлтгүй явж ирлээ. Манай улс АИ 92 авто бензиний гаалийн албан татвараас сардаа 9 орчим, жилдээ 100 орчим тэрбум төгрөг, дизель түлшнээс сардаа 25 орчим, жилдээ 300 орчим тэрбум төгрөгийн орлого олдог тэр хэмжээгээр төсвийн орлого хасагдах эрсдэлтэй байна.

Олон улсын нөхцөл байдалтай холбоотойгоор газрын тосны бүтээгдэхүүний гаалийн албан татварын хувь хэмжээг тогтоох эрхийг Засгийн газарт олгосноор зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулж шатахууны үнийн хэлбэлзлийг түргэн шуурхай зохицуулах боломж бүрдэх ач холбогдолтой юм.

Иймд “Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 27 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд оруулах өөрчлөлтийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр батлах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр боловсруулсан болно. Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа танилцуулна.

**Д.Үүрийнтуяа:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 3 сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлснийг Улсын Их Хурлын 2026 оны 3 сарын 20-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэж, Төсвийн байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн хуралдаанаар тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явууллаа.

Хууль санаачлагч Ойрх Дорнодод үүссэн нөхцөл байдлын улмаас дэлхийн зах зээл дээрх газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт, үнэд эрс өөрчлөлт орж байгаа үнийн түвшний өсөлт бий болох эрсдэл өндөр байгаатай холбогдуулан өргөн хэрэглээний бүтээгдэхүүн болох авто бензиний гаалийн албан татварын хувь хэмжээг Улсын Их Хурлаас тогтоосон хязгаарт багтаан тогтоох эрхийг Засгийн газарт олгох, зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан зохицуулалт хийх боломжийг бүрдүүлэх зорилгоор “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдаваа газрын тосны бүтээгдэхүүний гаалийн албан татварын хувь хэмжээг тогтоох эрхийг Засгийн газарт олгож байгаа нь газрын тосны дайвар

бүтээгдэхүүний үнийг бууруулж, хуурамч шатахууны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх эрсдэлтэй эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан манай улсын шатахууны нийт хэрэглээний хэдэн хувийг дизель түлш, хэдэн хувийг АИ 92 авто бензин эзэлж байгааг тодруулж, дээрх үнийн өсөлтөөс хамааран аж ахуйн нэгж, иргэдэд үүсэх хүндрэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа Газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлтийн төсөвт үзүүлэх нөлөөллийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Номин хаврын тариалалт эхэлж байгаа энэ үед тариалан эрхлэгчид 1 тонн дизель түлшийг хэдэн төгрөгөөр худалдаж авах, мөн улсын дизель түлшний нөөцийн хэмжээ болон хомсдол үүсэх эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Батжаргал Гаалийн албан татвар нь дотоодын зах зээлд үндэсний үйлдвэрлэлээ хамгаалдаг тохируулгын татвар бөгөөд дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн өсөлтөөс аж ахуйн нэгж, ард иргэдээ хамгаалах зорилгоор газрын тосны бүтээгдэхүүний гаалийн албан татварын хувь хэмжээг Улсын Их Хурлаас тогтоосон хязгаарт багтаан тогтоох эрхийг Засгийн газарт олгох нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг манай улсын уул уурхай, хөдөө аж ахуйн салбарын бүтээн байгуулалтын үйл ажиллагаа нь газрын тосны бүтээгдэхүүний үнэ, хангамжаас хамааралтай тул тэдгээрийн төсөв зардлын хэмжээ хэлбэлзэх эрсдэлтэй байгааг анхаарч, цаашид эдгээр салбаруудад ногоон шилжилт хийх асуудлыг төрөөс бодлогоор дэмжих нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа дэлхийн зах зээл дээр газрын тосны үнийн өсөлт манай улсын эдийн засагт нөлөөлөх тул энэ эрсдэлээс иргэд, аж ахуйн нэгжийг хамгаалахад төрөөс тодорхой бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй. Мөн үнийн өсөлт нь төсөвт урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас тодотгол хийх нөхцөл үүсэж байгааг анхаарах нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн 63.2 хувь буюу олонх дэмжиж, тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Буриадын Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Чулууны Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Сангидоржийн Баярмаа Гаалийн ерөнхий газрын Татвар орлогын газрын дарга.

Одоо Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаачлагчийн илтгэл, тогтоолын төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын

бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. Цэвэгдоржийн Туваан гишүүн.

**Ц.Туваан:** Бид бүхэн яг нөгөө дайнаа ирэхээр дариа нухна гэдэг шиг л юм болж байна. Энэ асуудлыг маш олон удаа ярьж байсан. Хэлж байсан. Тэгээд хэцүү нөхцөл байдал үүсэх нь гээд ярьж байсан боловч бид бүхэн шат шатдаа Улсын Их Хурал ч тэр, Засгийн газар дээр ч тэр, ард иргэд ч тэр улс төржсөөр байгаад яг өнөөдрийн ийм байдалд хүрч байгаа юм.

Бид нар газрын тос боловсруулах үйлдвэр дээр хэчнээн их шүүмжилж, хэчнээн их ажлыг нь шийдэж өгөхгүй гацааж, тэр нэмэлт санхүүжилт энэ тэр дээр яаж улс төржиж байлаа. Тэрнийхээ горьг бид нар амсаад явж байна. Өнөөдөр бид нар яг энэ салбар дээр аргаа ядсан арга буюу онцгой албан татварыг тэглэж, үнийг бага зэрэг бууруулах асуудал ярьж байна. Энийг бид нар углуургаар нь улс төржихгүй шийдчих маш их боломжоо алдсан. Одоо тэрийгээ бид бүхэн бас ойлгох ёстой. Тэгээд онц чухал, ялангуяа эрчим хүч, хүнс хоолтой холбоотой асуудлууд дээрээ бол бага улс төржмөөр байгаа юм гэдгийг бас хэлмээр байна.

Би бас хэлээд байгаа юм. Энэ 2 улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг оруулж ирж байхад юу гэж байлаа. Энэ 2 хэлэлцээр цуг шүү. Ингээд ийм учир жанцантай гээд яриад байхаар бараг л Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлыг өгөх гэж байна. Яах гэж байна билээ. Энд бид нарын дунд яг тэрийг яриад сууж байсан хүмүүс сууж байгаа өөдөөс хараад. Тэгэхээр энэ тэрээс болоод бид нар нефть импортолж байгаа ОХУ-ынхаа эсрэг ч юу байх вэ, ОХУ-ынхандаа үзүүлэх цаасгүй сууж байгаа шүү дээ. Тэгээд л төрийн 3 өндөрлөгөө гуйлганд явуулаад л, салбарын сайдуудаа гуйлганд явуулаад л ингээд л явдаг ийм асуудал үүсэж байгаа юм. Одоо тэгээд тэр цагаас хойш 1 жил гаран өнгөрчхөөд байгаа. Одоо дөнгөж 2 дахь хэлэлцээрийн асуудал Байнгын хороогоор ороод явж байгаа. Бид нар удаан байна. Тэгэхээр энэ дээр бид бүхэн энэ асуудлаа иймэрхүү чиглэлийн ялангуяа эрчим хүч, шатахуунтай холбоотой асуудлаа улс төржмөөргүй байна гэдгийг дахиж хэлье. Одоо ингээд дагаад яах вэ, өнөөдөр зүүн аймагт 670 км-ийн цаана байгаа Дорнодод 1 литр дизель түлш жижиглэнгийн үнэ 3800 төгрөг болчихсон байна. Одоо дахиад нэмэгдэнэ. Одоо тэндээс зөөх нөгөө ноос ноолуур, хаврын махны үнэ дагаад нэмэгдээд л ороод ирнэ. Бүх юмны үнэ нэмэгдэнэ. Тэгээд яг одоо бид нарын хамар доор тулж ирчхээд байгаа асуудал энэ хаврын тариалалт. Энэ үед түлш маш их хэрэг болдог. Бүр зээлээр 50 хувийг нь өгөөд явдаг байсан. Харин энэ дээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам энэ тэр ярилцаад, 3400-гаар юу хийж байх шиг байгаа юм. Барьер тавиад 100 хувь төлүүлээд хийнэ гэж байх шиг байгаа юм. Энэ бас л нөгөө ниргэсэн хойно нь хашхирч байгаа л асуудал. Тэгэхээр иймэрхүү зүйлүүд байна. Тэгэхээр одоо өнөөдрийн энэ асуудлыг хэдүүлээ бас бага улс төржөөд, дэмжээд, гялс гаргаад бас 1 литр тутамд энэ хэдэн төгрөгөөр буурах юм. Тэгээд 200 орчим төгрөгөөр өсөлтийг нь барих ийм боломж бүрдэх юм шиг байгаа юм. Тэгэхээр энийг дагаад улсын төсөвт орж ирэх татвар хураамжийн мөнгө багасна л гэсэн үг. Дахиад л нөгөө бүсээ чангалах л асуудал яригдана. Тэгэхээр бол ийм саналтай байна.

Дээрээс нь бид нар бас тэр 2 улсын Засгийн газар хоорондын юм дээр энэ газрын тосны салбар дээрээ хардаа, 2012, 2013 оны үед 1,1 сая тонныг бид нар олборлоод, экспортод гаргаж байсан энэ газрын тос чинь өнөөдөр өнгөрсөн 2025 онд 460 мянган тонн, энэ жилд 360 мянган тонн болоод бараг 3 дахин буурах гэж

байна. Энэ дээр дандаа л эсрэг юм ярьсаар байгаад л ийм болгож байгаа юм. Тэгэхээр энэ асуудлууд дээр бага улс төржмөөр байна. Хэдэн төгрөгөөр буурах .../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хэллээ. Ажлын хэсэг 4 номер.

**Ч.Хишигдалай:** Гаалийн албан татварыг авто бензин, дизель ... уучлаарай. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. Гаалийн албан татварын 5 хувийг тохируулах эрхийг Засгийн газарт олгосноор авто бензин дээр литр тутам 150-230 төгрөг, дизель түлш дээр 250 орчим төгрөгөөр буулгаж, үнийг бас жижиглэн худалдаан дээр хямдруулах боломж үүснэ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ренчинбямбын Сэддорж.

**Р.Сэддорж:** Монгол Улс шатахууны 95 хувийг 1 улсаас авч, үнэ өсөх бүрд эдийн засаг бүхэлдээ доргиж байгаа. Тэгээд дараах хэдэн асуултыг асууя.

Үнийн өсөлт дээр шатахууны үнэ өссөн нь гадаад хүчин зүйл хэдэн хувь байна. Дотоод бодлогын алдаа хэдэн хувь байна вэ. Албан тооцоо байгаа юу. Төрийн зүгээс үнэ барих бодлого явуулж байсан бол яг ямар механизмаар байсан, одоо яагаад цуцлагдсан байгаа вэ.

Импортын одоо 95 хувийн 1 улсаас хамааралтай байгаа нь Үндэсний аюулгүй байдалд ямар эрсдэл бий болж байна. Мөн хөрш зэргэлдээ улсуудаас БНХАУ-аас авах боломжийг албан ёсоор судалсан, гарсан дүгнэлт байна уу.

Шатахууны үнийн өсөлтөд гаалийн татвар, тээвэр, хадгалалтын зардал тус бүр ямар хувиудыг эзэлж байна вэ. Энэ дээр тодорхой хэлээч ээ.

Шатахууны үнэ өсөхөд инфляц хэдэн функтээр өсөх вэ. Шатахууны үнэ 10 хувь өсөхөд инфляц хэдэн функтээр өсөх ийм тооцоолол байна вэ.

Тээвэр, хүнс, барилгын материалын салбарт дам нөлөөллийн тооцоо яаж гарч байна вэ гэдгийг. Мөн газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орох хүртэл түр бодлогын шийдэл гэж энийг үзэх үү. Эдгээр асуулт дээр хариулт авъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн урилгаар Дорнод аймгийн Найнги ХХК-ийн ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. Та бүхэнд сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Ажлын хэсэг хариулья.

**Ч.Хишигдалай:** Ажлын хэсгийн гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай.

Гаалийн 5 хувь бол нийт жижиглэнгийн үнийн 4 хувь дээр нөлөөлөл үзүүлдэг. Гадаад нөхцөл байдлаар байдал дээр хийсэн судалгаан дээр бол газрын тосны үнэ өөрөө бол 60 орчим хувь өсөөд байгаа. Бэлэн боловсруулсан бүтээгдэхүүн буюу дизель түлш, авто бензиний үнэ бол 110 орчим хувийн өсөлттэй гадаадын бирж, олон улсын бирж дээр борлуулагдаж байна.

Манай дотоодын хувьд бол яг өнөөдөр ирсэн ОХУ-аас ирсэн хил үнээр болбол дизель түлшний үнэ 68 хувийн өсөлттэй байна. Бид энэ үнийн өсөлтийг бууруулах бүх боломжит хувилбаруудыгаа бэлтгэл болгоод, үүний 1 нь бол энэ импортын албан татварын хувь хэмжээг тохируулах Засгийн газарт эрх олгох тогтоол байна.

Бодлогын хувьд бол БНХАУ-аас импортлох асуудлыг бол бид нар өнгөрсөн хугацаанд аль болохоор импортын тоо хэмжээг нэмэгдүүлэх, импортоор оруулж нэвтрүүлэх боомтуудын тоо хэмжээг нэмэгдүүлэх гэх мэтчилэн арга хэмжээнүүдийг авч байна. Тухайлбал, Шивээ хүрэн боомтоор бид нар импортлох асуудлыг 2 улсын хилийн комиссын уулзалтуудаар шийдвэрлээд, 2 талдаа аюултай ачаа болон газрын тосны бүтээгдэхүүнийг гаалийн хяналтын талбайг байгуулаад нэвтрүүлэхэд бол бэлэн болсон байсан. Гэхдээ сая Ойрх Дорнодод үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор БНХАУ 2 сарын хугацаанд газрын тосны бүтээгдэхүүн, бэлэн бүтээгдэхүүнийг экспортлохыг бол хориглохыг байгаа. Цаашид бол энэ хоёрдогч, гуравдагч орнуудаас импортлох асуудлуудыг бид тодорхой хэмжээнд судлаад явж байна. Тухайлбал,, Бүгд Найрамдах Казахстан Ард Улстай газрын тосны салбар бүтээгдэхүүний чиглэлээр хамтын ажиллагаагаа өргөжүүлэх санамж бичиг байгуулахаар 2 улсаас төслөө солилцоод явж байна.

Газрын тос боловсруулах үйлдвэр бол ашиглалтад орох үед өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээний 50-55 хувийг хангаад явах боломжтой. Хариулж дууслаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Лувсаннъямын Гантөмөр.

**Л.Гантөмөр:** Уг нь бол ингээд татвар тэглэж байгаатай холбоотой асуултуудаа бид нар Ерөнхий сайдаас асуумаар байгаа юм. Яагаад гэхээр энэ дизель түлшний үнийн нэмэгдэл бол бензиний үнийн нэмэгдэл бол шууд хүмүүсийн амьдралд нөлөөлж байгаа юм. Энэ нөлөөллийг өнөөдөр Ерөнхий сайд маш тодорхой болгочихсон сууж байх учиртай л даа. Ийм нөлөөлөл үзүүлэх юм байна. Бид бол мөнгөний бодлого дээрээ ингэх юм байна. Төсвийн бодлого дээрээ бид ингэх юм байна гээд. Тэгээд одоо 2019 оны Үндсэн хууль баталсан хүмүүс 1 зүйлийг Дэгийн хуульдаа их тодорхой оруулах ёстой гэдэг нь ингээд нотлогдож байгаа юм. Сайдгүй. Бид бол сайдаас асуулт асуумаар байдаг. Ерөнхий сайд болохоор чуулганд яг одоогийнх шиг ингээд тааллаараа орж ирдэг. Яг Үндсэн хуулиар бол парламентын өмнө хариуцлага хүлээж байгаа ганцхан хүнтэй болчихсон. Ерөнхий сайдтай. Тэгэхээр одоо Бямбацогт энэ Их Хурлын даргаар томилогдох юм бол ерөөсөө парламентын хэлэлцүүлэгт Ерөнхий сайдтай л ордог болох хэрэгтэй. Ерөнхий сайдын өмнөөс сайд нар асуултад хариулдаг, бодлого ярьдаг, мэдэмхийрдэг ийм зүйлийг бол үндсэндээ энэ дэгээс Бямбацогтоо халах хэрэгтэй. Ингэж байж Үндсэн хуулийн чинь үзэл санаа бол амьдарна. 1 үгээр хэлбэл Монголын парламентын өмнө ганц хүн огцроод, ганцхан хүн томилогдож байгаа биз. Засгийн газрын гишүүдийг ерөөсөө энэ парламентад тангараг өргүүлдэг, барьдаг ийм зүйлийг болих хэрэгтэй. Ерөнхий сайд дэг .../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Яг тухайн асуудлаараа биз дээ. Гантөмөр гишүүн тодруулъя.

**Л.Гантөмөр:** Тэгээд Ерөнхий сайдад үг дайя. Одоо телевизээр үзэж байгаа бол. Төсвийн тодотголоо яаралтай оруулж ир ээ. Тэгэхгүй бол яг өнөөдрийн энэ тогтоолоор бол 250 тэрбум төгрөг наад зах нь алга болно. Үнийн өсөлттэй холбоотой эдийн засгийн эрчимжилт бол саарна. Яг тэрэнтэй холбоотойгоор маш

тодорхой татварын орлого алга болно. Өнөөдөр 700 тэрбум төгрөг татварын орлого дутчихсан байгаа. Тийм учраас төсвийн тодотгол бол яаралтай орж ирэх шаардлагатай шүү гэдгийг асуунгаа хэлье. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал уу. Дашдондогийн Ганбат.

**Д.Ганбат:** Ерөнхийдөө тогтоолын төслийг дэмжиж байна. Гэхдээ бас хэдэн үг хэлмээр байна. Ганц асуулт асуучихмаар байна.

Ер нь дэлхий нийт, дэлхийн энэ олон улс орнууд сорилтын өмнө тулгарчхаад байна. Энэ хүнд хэцүү үед Монгол Улсаа бид хэд яаж аятайхан аваад гарах вэ. Авлигач, хулгайч энэ хүмүүстэй яаж барьцаалагдахгүй байх вэ гэдэг юмаа бас бодох хэрэгтэй байна. Тэгэхгүй бол энэ бензин тос тосны үнээс авхуулаад бүх юмны үнэ нэмэгдэнэ. Бүгд цаанаас нь энэ ард түмэн талбай дээр гараад ирэхэд бол та нар дийлэхгүй шүү. Энэ олон жил засагласныхаа хариуцлагыг та нар хүлээнэ шүү нөхөд минь. Тэр 105 их наядаар гулгиж байхдаа юу хийж байсан юм бэ. Тэр их мөнгөөр 5 жил. 1 удаа тийм нөөц сав хийчихгүй яасан юм бэ. Хийсэн үү. Яагаад хийгээгүй юм тэрийг асууя.

Тэр нефтийн үйлдвэр чинь хэзээ орох юм бэ. Хэчнээн их мөнгө зардаг юм бэ. Орчихсон хойноо тэр нефть нь хаана байгаа юм бэ. Тэгээд яахаараа бид нар ганцхан улсаас, ганцхан улс дотроо ганцхан компаниас хамаарах ёстой юм. Яагаад ийм ажил төрлөө хийж чаддаггүй, чадваргүй сайдуудаар Засгийн газраа бүрдүүлдэг юм. Ер нь заригийн хэмжээний нөхөд л байна шүү дээ. Мэдээлэл авдаг нь 70 хувь нь. Тэр дотор л ордог юм уу хаашаа юм. Рэгдэл гуай бид 2 л арай өөр юм шиг байгаа юм. Ямар хоол идэж байна, ямар мэдээлэл авч байна гэдгээрээ тэр хүнийг тодорхойлж болно л доо. Тэгээд л хачин хачин юм яриад л. Ийм л байх ёстой юм шиг. Ганцхан компаниас хамаарна. Ганцхан улсаас хамаарна. Үгүй ээ, одоо энэ ашигт малтмал, газрын тосны газар, танай яамныхнаас хэчнээн хүн Авлигатай тэмцэх газар байна. Ямар асуудлуудаар байна. Ийм нөхдүүд ажил хийгээд, ийм байдалд оруулаад байгаа байхгүй юу. Ийм сэтгэлгүй байна.

Одоо энэ бензин тос чинь хэд хүрэх юм. Та нарын төсөөлөл ямар байна. Зүгээр мэдээлэл гэж ярихад өнөө өглөө л гэхэд АНУ цэргээ татчихлаа шүү дээ. Иранаас, Ормузын хоолойгоос. Ингээд л нефтийн үнэ бууж болно бас. Ийм зүйлүүдийг тооцож, энэ хэмжээний мэдээлэлтэй байж байж шийдвэр гаргаж чаддаг тийм хүмүүс бид нарт хэрэгтэй байна. Тэгэхгүй одоо тэгээд асуудалд яг өөрсөд шигээ ханддаг. Тэгээд авлига, албан тушаалын хорхойтой болчихсон. Тэргүйгээр амьдарч чадахгүй болчихсон. Энэ хэдэн нөхөд ингэж явсаар байгаад энэ улс орныг дуусгалаа шүү. Энийг одоо өөрчлөх цаг болсон. Үүний нэг илэрхийлэл нь өнөөдрийн энэ тогтоолын хэлэлцэж байгаа байдал байхгүй юу. Ер нь би хэд хоног энэ Улсын Их Хурал дээр сууж бас жоохон юм ярья гэж бодоод байгаа юм. Энэ асуудалд яаж хандах ёстой юм. Ямар хандлагатай байх ёстой юм. Энийг хэлье гэж бодож байгаа. Хариултаа авчихъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ажлын хэсэг 4 номер.

**Ч.Хишигдалай:** Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. Олон улсын нөхцөл байдлыг бол бид тогтвортой ажиглаж байгаа. Маш сайн ажиглаж байгаа. Маш сайн судалж байгаа. Өнөө өглөө

гэхэд 99 ам.доллар байсан. Америкууд цэргээ татаад, яг одоо 108 ам.доллар болчихсон байна. Газрын тосны үнэ. Олон улсын бирж дээр 1 бичигдсэн дүрэм эвдэгдээд байгаа нэг юм байгаад байгаа юм. Өмнө нь бид брэнд газрын тостой бүтээгдэхүүний үнийг уясан байдлаар хардаг байсан. 20 хувийн үйлдвэрлэлийн зардал нэмэгдээд, одоо 100 доллар байхад 120 ам.доллороор дизель түлшний үнэ зарагддаг байсан. Гэтэл өнөөдөр энэ тогтсон дэг журам нь зөрчигдсөн байна. Бэлэн боловсруулсан бүтээгдэхүүний үнэ бол яг Сингапур плас бирж дээр 120 хувийн өсөлттэй байна. 220 ам.доллар байна. Яг энэ үнээр бид нар бас цаашид үргэлжилбэл 5 сард бас нэлээдгүй өсөлтийг үзэх байх, өсөлттэй байх болов уу гэсэн таамаглалтай байна. Тэгэхдээ энэ олон улсын нөхцөл байдал өдөр өдрөөр өөрчлөгдөж байгаа учраас бид нар яг одоо бол тэд, эд гэж шууд хэлж чадахгүй. Биржээ бол ажиглаад ингээд үнийн хэлцлийн асуудлуудыг хөрш орнуудтай, нийлүүлэгчид компаниудтайгаа бас ярилцаад л явж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Гишүүд асуулт асууж .... Ганбат гишүүн.

**Д.Ганбат:** Бид нар чинь авлигын индексээр нэгхэн жилийн дотор 10 байраар ухарчхаад байгаа шүү дээ. 124. Би тэгээд асууж байгаа юм. Танай яам, танай тэр Ашигт малтмалын газар хэчнээн хүн Авлигатай тэмцэх газар байгаа юм бэ. Ямар асуудлаар байгаа юм бэ. Маш их мөнгийг авлигад авдаг гэж байгаа, өгдөг гэж байгаа. Ийм явдал байхад бид нар тэгээд, ард түмнээсээ татвар аваад, тогтоолын төслөөр дээш, доош нь болгоод ийм юмнаасаа эхлэх хэрэгтэй гээд би хэлээд байна шүү дээ. Тэр тоо баримт тийм нууц юм уу. Эсвэл мэдэхгүй байгаа юм уу. Мэдэхгүй болтлоо ийм болчихсон юм уу энэ улс орон чинь, энэ хүмүүс чинь, энэ ажил хийж байгаа хүмүүс чинь. Би ард түмнийг төлөөлөөд асууж байна. Ийм байх ёстой юм уу. Ямар байх ёстой юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номер.

**Б.Дашпүрэв:** Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Дашпүрэв. Ганбат гишүүний асуултад хариулъя. Боловсруулах үйлдвэр 2028 оны эхний улиралд ашиглалтад орохоор ажиллаж байгаа.

АМГТГ болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ажиллаж байгаа хүмүүсээс Авлигатай тэмцэх газарт шалгагдаж байгаа хүн байхгүй болно. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Тогтоолын төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрс алга байна.

Одоо Байнгын хорооны саналаар “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүдийг чуулганы зааланд хүрэлцэн ирэхийг урьж байна. Гишүүдийг танхимд урьж байна. Гишүүд санал хураалтад бэлдье. Болсон уу.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 114 гишүүнээс 67 гишүүн дэмжиж, 58.8 хувиар тогтоол батлагдлаа.

Доржханд гишүүн, Одонтуяа гишүүн, Батчимэг гишүүн.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг

17.02 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Э.СУВД-ЭРДЭНЭ*